




СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.02.13 №06 (10683)


Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

ЭЛЧИН САЙДУУДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чай Вэнь Рүй



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И Ёо Хун

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2 дугаар сарын сарын 6-ны өдөр БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чай Вэнь Рүйг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр талууд хоёр улсын эртний уламжлалт найрсаг харилцааг цохон тэмдэглээд дипломат харилцаа тогтоосноос хойш энэхүү харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүрч, хурдацтай хөгжиж, улс төрийн харилцан итгэлцэл гүнзгийрч, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа улам бүр өргөжиж байгааг онцлолоо. Батлан хамгаалахын сайд Н.Энхболд “Эрхэм Чай Вэнь Рүй таныг хариуцлагатай албанд томилогдсонд баяр хүргэе. Хоёр орны харилцааны чухал хэсэг болох Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд тасралтгүй өргөжин хөгжиж, олон

хэлбэр, агуулгаар баяжин, бодит үр дүнд хүрч, хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Хоёр талын хамтын ажиллагаа, тэр дундаа цэрэг-техникийн хамтын ажиллагаа цаашид улам гүнзгийрэн хөгжинэ гэдэгт итгэлтэй байна” гэсэн юм.

Мөн Батлан хамгаалахын сайд Н.Энхболд ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизовыг өөрийнх нь хүсэлтээр 2 дугаар сарын 10-ны өдөр Батлан хамгаалах яаманд хүлээн авч уулзсан. Элчин сайд И.К.Азизов ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгугаас Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболдод ирүүлсэн Олон улсын аюулгүй байдлын Москвагийн 9 дүгээр бага хуралд оролцох урилгыг гардуулж өгсөн бөгөөд талууд хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өндөр түвшинд

хөгжиж байгааг онцолж, хоёр орны цэргийн хамтын ажиллагааны талаар 2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн талаар санал солилцсон юм.

Мөн энэ өдөр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд БНСУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И Ёо Хунийг Элчин сайдын үүрэгт ажилд томилогдсонтой нь холбогдуулан өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзав. Уулзалтаар Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Элчин сайдын албан тушаалд томилогдсонд нь баяр хүргэж, Монгол Улс, БНСУ-ын цэргийн харилцаа нь хоёр орны цэргийн харилцааны суурь эрх зүйн баримт бичгийн хүрээнд тогтмол өргөжин хөгжиж байгааг дурдав. Мөн хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ой тохиож байгаа энэ онд хоёр орны харилцаа стратегийн түншлэлийн түвшинд шинэ шатанд гарч хөгжинэ гэж найдаж байгаагаа илэрхийлсэн юм.

ХИЛИЙН ЧАНАДААС ...

АНУ, ИХ БРИТАНИЙН ЦЭРГИЙН БАГТАЙ ХАМТАРСАН СУРГАЛТ ХИЙВ

ИБНАУ-д явагдаж байгаа “Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын Х ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн “Шинэ Кабул” баазын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэг болоод баазын штаб, удирдлагаас өгсөн нэмэлт үүргүүдийг амжилттай гүйцэтгэсээр байна. Цэргийн багийн бие бүрэлдэхүүн ажиллагааны газар оронд очихоос өмнө буюу Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлд хамрагдсанаас хойш нягт хамт олон болон



төлөвшиж чадсаны дүнд үүрэг гүйцэтгэж байгаа олон орны дайчдын тэргүүн эгнээнд

манлайлж явна. Өнгөрсөн нэгдүгээр сард дэмжлэгийн салаа болон мотобуудлагын

тасгуудын хооронд болзолт уралдааныг зарлаж, цэргийн алба, сахилга, зохион

байгуулалт, ажиллагааны үүрэг гүйцэтгэлт, сургалт, соёл хүмүүжил, бие бялдрын шалгуур үзүүлэлтүүдийг хангах гэсэн дөрвөн үндсэн үзүүлэлтийг долоо хоног бүр дүгнэж, сарын тэргүүний тасаг, офицер, ахлагчаа шалгаруулж урамшууллаа. Мөн АНУ, ИБУИНВУ-ын цэргийн багуудтай хамтран эмнэлгийн зааварлагч, гар хийцийн тэсэрч дэлбэрэх хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт, ажиллагааны зарчим, учруулж болох хөнөөлийн тухай сургалтыг явуулж, бие бүрэлдэхүүний мэдлэг, чадварыг нэмэгдүүлэн дадлагажуулав.

Ахлах дэслэгч Б.МӨНХТУУЛ

Ярилцах цаг

Б.Амгаланбаатар: ШТАБЫН БЭЛТГЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ОНЦГОЙ АНХААРЧ БАЙНА

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.АМГАЛАНБААТАРТАЙ цаг үеийн асуудлаар ярилцлаа.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаар сонин сайхан юу байна вэ? 2019 он танай командлалын хувьд түүхэн жил байлаа ...

-Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын хувьд 2019 он нэлээд ачаалалтай, их ажлын жил байлаа. Ялангуяа командлал үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн жил байсныг та бүхэн мэднэ. Өнгөрөгч онд Хуурай замын цэргийн командлалын бие даасан байдлыг хангах, цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, цэргийн захиргааны байгууллагыг төлөвшүүлэх чиглэлээр нэлээд ажиллалаа. Командлалын шинэ байраа ашиглалтад хүлээн авч, шилжин байрлалаа. Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ-2019” тактикийн хээрийн сургуулийг

Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд Дорнод аймагт зохион байгуулсан. Энэ удаагийн сургуулийн онцлог нь хоёр талаасаа нэлээд олон хүн хүч, техник оролцуулсанд байгаа юм. Тэр дундаа ОХУ-ын Зэвсэгт хүчний нисгэгчидирж оролцсоныг дурдах ёстой. ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу 2018 онд Монгол Улсад айлчлах үедээ Зэвсэгт хүчний 337 дугаар ангид тусламжаар өгсөн нислэгийн газрын удирдлагын техник хэрэгслийг “Сэлэнгэ-2019” сургуулийн үеэр иж бүрнээр нь дэлгэж, удирдлагыг 100 хувь хангаж ажиллалаа. Хүн, техник хоёр хоёулаа үүргээ сайн гүйцэтгэсэн. Түүнээс гадна Халхын голын байлдааны оргил үе буюу 1939 оны 8 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд явагдсан байлдааны ажиллагааны хамгийн жижигрүүлсэн хувилбараар нь

уг сургуулийн ажиллагааны бодлогыг тодорхойлсон нь үр дүнтэй болсон. Ялангуяа тухайн үед оролцож байсан морьт механикжуулсан холимог цэргийн бүлэглэлийг орчин үеийн техниктэйгээр зохион байгуулснаараа онцлог байв. Мөн хэд хэдэн орон нутгийн дайны үед хэрэглэж байсан арга, тактикуудыг ч туршиж. Тухайлбал, “Т-72” танкийн галын эргүүлэг, танк эсэргүүцэгч хэрэгслийн галын эргүүлэг, агаарын цельтэй тэмцэх зенитийн буг хөдөлгөөнт байдлаар ашиглах зэргийг туршснаараа ач холбогдолтой байлаа.

Командлалын харьяа нэгтгэл, ангиудын хувьд ч мөн адил өнгөрөгч онд алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, ая тухтай орчин нөхцөлд ажиллах боломжийг нь бүрдүүлэх үүднээс нэлээдгүй ажлыг хийсэн. Жишээлбэл, Зэвсэгт хүчний 167, 256, 336, 340 дүгээр ангид өөрсдийн нөөц бололцоог ашиглаад цэргийн гал тогоо, тавиулан,

штабуудынхаа засварыг хийсэн гээд цөөнгүй жишээг дурдаж болно. Мөн төмөр замын бүтээн байгуулалт явагдаж байгаатай холбоотойгоор Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн хадгалалтад байсан нэг байрыг шинэчлэн засварлаад Монголын төмөр замын ажилчдыг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоогоор нь хангаж өгсөн.

Сургалт бэлтгэлийн хувьд ...

-Цэргийн хүний гол хөдөлмөр нь сургалт бэлтгэл байдаг учраас энэ чиглэлд онцгой анхаарч байна. Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан бүх арга хэмжээг, тэр дундаа хээрийн гаралт, полигоны дадлага, танхимын хичээлийг бүрэн явуулсан. Хуурай замын цэргийн командлал шинэ байранд шилжин байрласантай холбоотойгоор командлалын тайван цагийн бүтэц, орон тоог шинэчилсэн бөгөөд энэ дагуу өнгөрсөн оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Мэдээж командлалын бие даасан байдлыг хангах чиглэл

рүү нэлээд ойртсон бүтэц, зохион байгуулалт болж чадсан. Тухайлбал, командлал өөртөө удирдлагын роттой боллоо. Энэ нь хээрийн холбоог дэлгэх, харуул хамгаалалтыг зохион байгуулах, агаарын халхлалтыг хийх зэрэг үүргүүдийг гүйцэтгэхэд боломж олгосон бүтэц юм. Цаашдаа улам төгөлдөржүүлээд явна.

2020 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ямар ажлууд байна вэ?

-2020 онд бид цэргийн захиргааны удирдлагыг тасралтгүй хэрэгжүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг бэхжүүлэх, байлдааны бэлэн байдлыг хангах гэсэн томоохон зорилго тавилаа. Энэ хүрээнд стратегийн төлөвлөлтийн шинэчлэлтэй уялдуулан оперативын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж дуусгах, хэрэгжилтийг нь хангах, нэгтгэл, ангиудын үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгыг дэвшүүлсэн.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЯРИЛЦАХ ЦАГ

Б.Амгаланбаатар: ШТАБЫН БЭЛТГЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ОНЦГОЙ АНХААРЧ БАЙНА

(Түрүүч нь I нүүрт)

Хоёрдугаарт, цэргийн бэлтгэл сургалтыг мэргэжлийн цэргийг бэхжүүлэх чиглэлд түлхүү явуулан штабын бэлтгэл сургалтыг төгөлдөржүүлж, төрөл мэргэжлийн цэргийг ашиглах дүрэм, зааврын хэрэгжилтийг ханган сурлагын чанарыг дээшлүүлэх зорилтыг тавьсан. Энэхүү зорилтын хүрээнд 2019 онд Артиллерийн байлдааны дүрэм, Цэргийн агаарын довтолгооноос хамгаалах байлдааны дүрэм, Хилийн хангалтын заавар, Тактикийн тагнуулын заавар гэсэн дөрвөн баримт бичгийг боловсруулж дууссан. Эдгээр баримт бичгүүдийг сургуулийн жилийн нэгдүгээр үед туршиж, тэндээс гарсан санал, дүгнэлтээ нэгтгээд хагас жилээр батлуулан мөрдөнө гэсэн төлөвлөгөөтэй байна. Гуравдугаарт, цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлж, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, дотоод хяналт, шалгалтыг тасралтгүй зохион байгуулах, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх явдал юм. Дөрөвдүгээрт, хүний нөөцийн бодлогыг мэргэжлийн цэргийг бэхжүүлэхэд чиглүүлж, цэргийн гэрээт албыг төлөвшүүлэх, тавдугаарт, Хуурай замын цэргийн ар тал, техникийн хангалтыг зохион байгуулахдаа төсөв хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зургаадугаарт, улс орны бүтээн байгуулалтад оролцох Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын төлөвлөлт, зохион байгуулалтад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх гэсэн зорилтуудыг тавин ажиллаж байна.

Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд командлалын харьяа нэгтгэл, ангиуд өргөн бүрэлдэхүүнтэй оролцож байгаа. "Тал нутагт цэргийнхэн хэрхэн бүтээж байгааг Дорноговь аймагс хараарай" гээд л иргэд тун ам сайтай байна лээ ...

-Баярлалаа. Одоогийн байдлаар командлалын харьяа найман ангийн тодорхой тооны бүрэлдэхүүн оролцож байна. 2019 онд Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь хүнд даацын авто замыг тодорхой бүрэлдэхүүн барьж, зарим нэгтгэл, анги өөрсдийнхөө үүрэг, чиглэлээр төмөр замын бүтээн байгуулалтад оролцлоо. Энэхүү жишиг энэ жил ч мөн үргэлжилнэ. Ер нь ажиглаж байхад цэргийн

алба хаагчдаас гадна хугацаат цэргийн алба хаагчид ч бүтээн байгуулалтын ажилд оролцох хүсэл эрмэлзлэл дүүрэн байна. Улаанбаатар цэргийн хүрээ болоод мотобуудлагын хороодоос бүтээн байгуулалтын ажилд оролцох хүсэл эрмэлзэлтэй олон тооны цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид хүсэлтээ ирүүлээд байна. Мэдээж судалж байж шийдвэрийг гаргана.

Өнгөрсөн онд манай бүтээн байгуулагч цэргийнхний хийсэн томоохон ажил бол Дорноговь аймагт баригдах Газрын тос боловсруулах үйлдвэрийн хүнд даацын авто зам юм. Манай залуус чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн, улсын комисст сайн үнэлгээтэйгээр хүлээлгэж өгсөн. Энэ бол манай инженерийн цэргийнхний хоёр жилийн хугацаанд маш их хүч хөдөлмөр зарцуулан барьж байгуулсан Монгол Улсад анхны олон улсын В2 ангиллын хүнд даацын авто зам юм.

Үргэлжлүүлээд тун удахгүй Тавантолгой-Зүүнбаянгийн чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд манай томилогдсон бүрэлдэхүүн оролцохоор бэлтгэл ажлаа саргаж байна. Гуравдугаар сарын 1-ний өдөр гэхэд гарна. Үүнтэй холбоотойгоор Хуурай замын цэргийн командлалын харьяа нэгтгэл, ангиудын сургалтын төлөвлөгөөнд тодотгол хийлээ. Бид өмнө нь жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрөөс хэрийн гаралтаа гардаг байсан бол бүтээн байгуулалтад оролцохтой уялдуулан энэ жил 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 3 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрийн гаралтуудаа зохион байгуулахаар тун шахуу ажиллаж байна. Яг одоогийн байдлаар гэхэд ихэнх анги нь хэрийн гаралтаа дуусгаад, бууж эхлээд байна. Нэгтгэл, ангиудын хэрийн гаралтуудаас хамгийн онцлогтой нь Зэвсэгт хүчний 256 дугаар ангийнх юм. Учир нь 25 жил буудаагүй байсан тийрэлтэт артиллерийн батареийг гаргаж, буудлага хийх гэж байна. Энэ долоо хоногийн сүүлээр байлдааны буудлагаа хийх бөгөөд үүнтэй уялдуулан командлалаас мэргэжлийн тодорхой бүрэлдэхүүн тус ангид томилогдон ажиллаж байгаа. Түүнчлэн дурдах ёстой бас нэг чухал арга хэмжээ нь 2019-2020 оны зааг дээр командлалын харьяа нэгтгэл, ангиуд шинэ



бүтэц, зохион байгуулалтад шилжсэн. Энэ бол үндсэндээ сүүлийн 20 жил хийгдээгүй нүсэр ажил байсан бөгөөд 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс шинэ бүтэц, зохион байгуулалтаараа үүргээ гүйцэтгэж байна.

Энэ нь ямар ач холбогдолтой вэ?

-Албан тушаалын нэршлийг нэг мөр болгох, ижил зэрэглэлтэй ангиудын албан тушаалтнуудын цалин, цолны зэрэглэлийг нэг мөр шийдэхэд маш чухал ач холбогдолтой. Хамгийн гол нь Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах боломжийг судалж үзээд суурь бүрэлдэхүүнээ хадгалж байх, тайван цагт цэргийн бага мэргэжилтэн бэлтгэх нөхцөл, бололцоог нэмэгдүүлэх чиглэл рүү бүтэц, зохион байгуулалтаа ойртуулсан байгаа. Мөн Зэвсэгт хүчний гол цөм болсон ахлагч нар хэрэв ажилдаа гаршиж, мэргэжлийн зэрэгтэй байж чадвал "ТТ-9" хүртэл шатлан дэвших боломжийг олгож байна. Офицеруудын хувьд ч ялгаагүй тайван цагт улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах, бэлэн байдлаа хангах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг тодорхой зааж орууллаа. Нөгөө талаар энэхүү өөрчлөлтөөр Зэвсэгт хүчний ангид нэгээс хоёр салбар тайван цагийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ байлдааны цагийн үүрэг гүйцэтгэх боломж бий болж байгаа. Энэ нь үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх зорилт руу чиглэсэн арга хэмжээ гэж ойлгож болно. Үүнтэй уялдуулаад стратегийн төлөвлөлтийн олон баримт бичгүүд шинэчлэгдэнэ. Ялангуяа нэн тэргүүний ээлжинд командлалын оперативын

байгуулалтын төлөвлөгөөг боловсруулна. Өнгөрсөн хугацаанд оперативын төлөвлөлтийн баримт бичгүүдийг бид ярьдаггүй байсан. Тэгвэл оперативын дэлгэн байгуулалтын төлөвлөгөө заавал байх ёстой гэсэн асуудлыг олон удаагийн команд штабын сургууль мөн стратегийн команд штабын сургуулиар дэвшүүлж санал нэгдсэн нь олзуурхуштай. Удахгүй болох стратегийн команд штабын сургуулиар энэ талаар нэгдсэн ойлголтод хүрэх байх. Цаашдаа өргөтгөн боловсруулаад аваад явах бүрэн боломж байна. Мөн энэ жилийн хувьд сургалт, дадлагад ашиглагдах байлдааны дүрэм, заавраа үргэлжлүүлэн боловсруулж, төгсгөлд нь эрх зүйн баримт бичгүүдээ эмхэтгэн үйл ажиллагаандаа мөрдөнө.

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтын үеэр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал 2020 оныг "Штабын бэлтгэлийг дээшлүүлэх жил" болгосноо зарлаж байна. Энэ тухайд ...

-Тийм ээ. Бид энэ жил штабын бэлтгэл болон удирдах бүрэлдэхүүний заах арга зүйг дээшлүүлэхэд онцгой анхаарна. Үүн рүү чиглэсэн олон арга хэмжээг төлөвлөж, эхнээсээ ажил хэрэг болгоод явж байгаа.

Командлалын дагаж мөрдөх ёстой эрх зүйн баримт бичгүүдийг цэгцлэх ажил урагштай байгаа гэсэн. Энэ тухай тодруулахгүй юу?

-Бие даан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш Хуурай замын цэргийн командлалын дотоод журам, Хуурай замын цэргийн командлалын дүрэм, Хуурай замын цэргийн

командлалын зөвлөлийн хурлын ажиллах журам, Хуурай замын цэргийн командлалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх салбарын зөвлөлийн үйл ажиллагааны журам, Хуралдаан зохион байгуулах журам зэрэг баримт бичгүүдийг командлалын хэмжээнд бүрдүүлсэн. Мөн Хуурай замын цэрэгт мөрдөгдөх Артиллерийн байлдааны дүрэм, Цэргийн агаарын довтолгооноос хамгаалах дүрэм, Үй олноор хөнөөх зэвсгийн хангалтын заавар, Тактикийн тагнуулын заавар гэсэн баримт бичгүүдийг боловсруулж дуусгасан. Яг одоо Улсын хил хамгаалалтад Хуурай замын цэрэг дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулаад холбогдох газруудаас санал авч байна. Цаашдаа Инженерийн хангалтын заавар, Сэтгэл зүйн хангалтын заавар, Артиллерийн гал удирдах дүрэм зэрэг олон баримт бичгүүдийг боловсруулах ёстой. Энэ ондоо багтан боловсруулж, хэрэглээнд оруулна гэсэн зорилттой ажиллаж байна.

Нийгмийн хамгааллыг дээшлүүлэх чиглэлд ...

-Офицер, ахлагчийн нийгмийн хамгааллыг дээшлүүлэх зорилгоор Батлан хамгаалах яамны дэмжлэгтэйгээр зөвхөн Хуурай замын цэргийн командлалын албан тушаалтны 30 айлын орон сууцыг барьж байна. "Монгол цэргийн өдөр"-ийн үеэр ашиглалтад орох болов уу. Саяхан барилгын явцтай танилцахад дотоод засалдаа орчихсон, 90 хувийн гүйцэтгэлтэй байна лээ. Албан тушаалын орон сууцыг шинээр барих болон засварлах ажил үүгээр дуусгахгүй. Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ашиглалгүй удсан 58 айлын орон сууц бий. Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулахдаа тэрхүү орон сууцыг хоёр талаасаа хөрөнгө гаргаад засварлана гэж тохирсон. Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн офицер, ахлагч нарыг оруулж хоёр байдлаар төлөвлөгөөнд тусгагдаад явж байна. Ер нь цаашдаа манай харьяа нэгтгэл, анги байрладаг орон нутгуудад албан тушаалын орон сууцыг барих талаар аймгуудын удирдлагуудтай хамтран ажиллах зайлшгүй шаардлага бий. Энэ чиглэлээр төлөвлөсөн ажлууд ч их байгаа.

Дэслэгч Д.БОЛОРМАА

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ...



Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн "Цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын салбар зөвлөл" болон "Техник, технологи, инновацийн салбар зөвлөл" тус тус хуралдаж, судалгааныхаа ажлын чиглэлээрээ хэд хэдэн асуудлыг хэлэлцсэн ажээ. Шинжлэх ухаан,

технологийн салбар зөвлөлүүдийн хурал нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулах, улмаар батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, Зэвсэгт хүчний шинэчлэлд тулгамдаж буй асуудлуудын хэрэгцээ, шаардлагыг нарийвчлан тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

ЭРҮҮЛ ЖОЛООЧИЙН ТАВАН ДАДАЛ

Битгий бөгтий. Нуруугаа гадил жимс шиг хэлбэртэй болгон бөгтийж жолоо барих нь таны эрүүл мэндэд маш муу. **Суудлаа зөв тохируул.** Өөрт хамгийн эвтэйхэн байдлаар автомашиныхаа суудлыг тохируулахын зэрэгцээ бүсэлхий хэсэгт тусгай дэр ивж суунал илүү үр дүнтэй. **Жолооны хүрдээ зөв атга.** Гарын цусны эргэлтийг

саатуулахгүйн тулд тохойноос үл ялиг дээр жолооны хүрдийг атга.

Биеэ амраа. Аль болох ойр ойрхон автомашинаасаа бууж, 15 минутын турш гар, хөлөө тэнийлгэх хэрэгтэй.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч, ахмад М.МӨНХБАЯР

Редакцын шууданд

123 дугаар анги

➢ Сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу зениг, артиллерийн салбарууд Ховд аймгийн Мянгад сумын, мотобуудлагын салбар сургуулийн төвийн районд хэрийн гаралт, дадлага сургуулийг зохион байгуулж байна.

➢ Дэлхий нийтээр хурдацтай тархаж байгаа коронавирусээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн бүрэлдэхүүн

коронавирусийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар яриа таниулга хийж, шалган нэвтрүүлэх байр, цэргийн байр, халуун ус, угаалга, цэргийн гал тогоо зэрэг газар ариутгал, халдваргүйжүүлэлтийг тодорхой давтамжтайгаар хийж байна. Мөн бие бүрэлдэхүүний төлөвлөгөөний дагуу биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлж, чийрэгжүүлэлтэд нь анхаарч байна.

Ахмад Э.ЗОЛЗААЯ

013 дугаар анги

➢ 2019-2020 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу нэг талын хоёр шатны команд штабын сургуулийг гурван үе шаттайгаар зохин байгууллаа. Зэвсэгт хүчний Штабын бэлтгэл сургалтыг зохион байгуулах зааврыг ашиглаж, шинэ зохион байгуулалтаар холбоочдын тусгай тактикийн хэрийн сургуулийн өмнө явуулсан нь онцлог байв.

➢ Бие бүрэлдэхүүнд дэлхий нийтээр тархаад байгаа коронавирусээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон хамт олон, гэр бүлээ хэрхэн хамгаалах талаар тогтмол яриа таниулга хийж байна. Үүний нэг нь ангийн удирдлага, эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран ангийн дотоод нөөц бололцоог ашиглан 520



ширхэг амны хаалтыг оёж, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад өглөө. Тус амны хаалтыг хэрэглэснээр коронавирусийн халдвар болон бусад агаар дуслын

замаар дамжин халдварладаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой болж байгаа юм.

Ахмад З.АНХБАЯР

350 дугаар анги

Салбарын офицерууд болон даргалах бүрэлдэхүүний ахлагч нарыг хамруулсан сахилгын зөвлөгөөнийг зохион явууллаа. Энэхүү зөвлөгөөнөөр "Салаа, салбарын офицер, ахлагч нарын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, гэмт

хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албандаа хандах хандлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, удирдах арга барилыг сайжруулах" гэсэн сэдвүүдээр илтгэл тавигдаж, нэгдсэн хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

М.БОЛОРТУЯА

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

Цэргийн төв эмнэлгийн Поликлиникийн хувьд анх 1921 онд тус эмнэлэг үүсгэн байгуулагдахад хамт тулгын чулуугаа тавьсан бөгөөд одоогоор зургаан тасаг, шуурхай дөрвөн бүлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ талаар Поликлиникийн дарга, клиникийн профессор, анагаах ухааны магистр, мэс заслын ахлах зэрэгтэй эмч, дэд хурандаа Б.Болор-Эрдэнэ "Цэргийн төв эмнэлгийн Поликлиник нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний алба хаагчид, тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчид, тэдгээрийн гэр бүл, харьяаллын үйлчлэх хүрээний болон харьяаллын бус иргэдэд амбулаторийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх үндсэн чиг үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна. Манай эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдийн ихэнх хувь нь Поликлиникээр дамжиж дараагийн тусламж үйлчилгээг авдаг онцлогтой. Нэн яаралтай үед шууд хэвтэн эмчлүүлэх хэсэгт хүргэгддэг. Энэ ч утгаараа Поликлиник нь тухайн эмнэлгийн нүүр царай болж, өндөр нэр хүнд, үүрэг хариуцлагыг дааж явдаг учраас эмч, сувилагч, үйлчлэгч нар маань ажил үүргээ гүйцэтгэхдээ үйлчлүүлэгчийнхээ сэтгэл ханамжийг дээдлэн хэл яриа, үйл хөдлөлөө тун сайн цэгнэдэг. Дараагийн дугаарт, өвчнийг нь эрт илрүүлэн оношилж, эрсдэлээс сэргийлэхээс гадна хяналтад авсан өвчтөнүүдийн эмчилгээ хэдий хэр хугацаанд хийгдэхийг нарийн зохион байгуулна. Цэргийн төв эмнэлэгт хэрэглэгдэж байгаа эмчилгээ, оношилгооны багаж, тоног төхөөрөмж бүгд Поликлиникт данслагддаг. Шинжилгээний хариуг хөдөлшгүй үнэн байлгахын тулд Поликлиникийн дүрс оношилгооны тасгийнхан өндөр хариуцлага хүлээдэг. Мөн лабораторийн тасаг нь олон улсын чанарын итгэмжлэл болох "ISO-15189"-ийг хэрэгжүүлэхээр бэлтгэлээ хангаж дууссан. Түүнчлэн эмнэлгийн ажилчид болон харьяаллын үйлчлүүлэгч нартаа эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулахын зэрэгцээ улирлын өвчлөлөөс сэргийлж вакцинуулалтыг зохион байгуулдаг. Ачаалал тун ихтэй. Энгийн үед өдөртөө 500-600 хүн хүлээж авдаг бол Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын болон энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад орох бүрэлдэхүүнд үзлэг явуулах үед энэ тоо 1000 хүрдэг" гэв.

Поликлиник нь мэс засал, дотор, эрүү нүүр, шүд, лаборатори, сэргээн засах, дүрс оношилгооны тасгуудтай. Эдгээр тасагт нийт 50 гаруй кабинет бий. Дотрын тасаг буюу арьс харшил, мэдрэл, сэтгэц, зүрх судас, өндөр настан, элэг цөс, уламжлалт, халдвар, сүрьеэ, хордлогын зэрэг кабинетаар үйлчлүүлж, үзлэгт орсон иргэдийн тоо жилд 10 гаруй мянгад хүрдэг. Мөн сэргээн засах тасгаар 146 мянга орчим хүн үйлчлүүлсэн гэсэн судалгаа ч байна. Бусад тасгийн хувьд ч ялгаагүй ачаалал ихтэй. Энд олон тоо дурдахаас илүүтэй Поликлиник нь эрүүл мэндийн даатгалын сантай хийсэн гэрээний дагуу оношилгооны гүйцэтгэл, амбулаторийн үзлэгийн гүйцэтгэл зэргийг хангалттай давуулан зорилго, зорилтоо бүрэн ханган ажилласан гэдэг үзүүлэлт уншигч танд нэгийг бодогдуулах биз.

Мөн тус хамт олон өнгөрсөн онд зарим кабинетийг шинээр бий болгох ажлыг эхлүүлсэн байна. Тухайлбал, сэтгэл заслын болон сэтгэл зүйчийн кабинеттай болох сууриа тавьжээ. Энэхүү эрэлт хэрэгцээг дэд хурандаа Б.Болор-Эрдэнэ тодорхойлохдоо "Хилийн чанадад үүрэг гүйцэтгээд ирсэн зарим цэргийн алба хаагч стресс тодорхой хэмжээнд өртдөг. Тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, тусламж үйлчилгээ үзүүлэх нь нэн чухал гэж үзээд өнгөрсөн оноос үйлчилгээндээ нэвтрүүлээд байна. Жишээлбэл, гэр бүлийнхнээсээ гирвэших ч юм уу, аль эсвэл хөндийрсөн ч гэмээр өвчтөнтэй манай эмч нар тулж ажилласан туршлагатай. Иймэрхүү тохиолдлууд байдаг юм билээ" гэв. Мөн ус, агаар мэт үгүйлэгдэж байсан тархины зөөврийн цахилгаан бичлэгийн аппараттай болсон баяраа ч хуваалцлаа. Тус аппаратын тусламжтайгаар өвчнөөс урьдчилан сэргийлэхээс гадна зарим шинжилгээг Цэргийн төв эмнэлэгтээ хийх боломж бүрдсэн аж. Түүнчлэн амьсгалын багтаамж үздэг аппаратыг энэ ондоо үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөөд байгаа гэнэ. Ингэснээр сүрьеэ, архаг бронхит зэрэг олон өвчнийг эрт оношлон илрүүлэх сайн цагийг урин дуудсан гэлтэй. Баярын мэдээ энэ хүрээд зогсоогүй. Шүдний ёзоорыг тоймлон хэмждэг байсан бол одоо компьютерын тусламжтайгаар нарийн тогтоож ямар хэмжээний ломбо орохыг нь тооцоолж чадахаар болсноос гадна судасны зөөврийн болон сонсголын аппараттай ч болоод амжжээ. Үүнээс гадна өнгөрсөн онд тус Поликлиник цусны сорьц уншдаг аппаратаа шинэчилсэн. Нэг цагт 60 хүний цусны сорьцыг уншдаг байсан бол одоо 80-ыг уншиж чадахаар болж хүчин чадал нь нэмэгдсэн. Үүний үр дүнд цаг хэмнэхээс гадна ажлын бүтээмж дээшилж, үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамрагдах иргэдийн идэвх ч тэр хэрээрээ сайжирна гэдгийг тус хамт олон онцолсон.

Дэд хурандаа Б.Болор-Эрдэнэ Цэргийн төв эмнэлэгт 14 дэх жилдээ ажиллаж байгаагаас сүүлийн гурван жил Поликлиникийн даргын албыг хашиж байна. Энэ хугацаанд БНХАУ, БНЭУ-д бүдүүн гэдэсний болон хэвлийн хөндийн мэс заслаар мэргэжил дээшлүүлж, гаднын орнуудад зохиогдсон хурал, зөвлөгөөнд тогтмол хамрагдан өөрийн мэдлэг, ур чадвараа ахиулан удирдах албан тушаалтан болоход өөрийгөө гологдохооргүйгээр бэлдсээр иржээ. Бас түүний удирдах арга барил нь даргалахдаа бус ажилчдынхаа оронд өөрийгөө тавьж үзэн тэдний найз бас сайн зөвлөгч нь байхыг хичээдэгт оршдог аж. Энэ занд нь бусад эмч, сувилагч хэдийнээ идээшсэн гэдэг нь үнэнээс хол зөрөхгүй болов уу.

Мөн тэрээр 2010 онд Зэвсэгт хүчний 339 дүгээр анги үүсэн байгуулагдахад суурийг нь тавилцаж эмнэлгийн албаны даргаар томилогдон ажлын гараагаа эхлүүлж байсан тэр өдрийг дурсаад үргэлжлүүлэн Афганистан улсад үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын анхны бөгөөд сүүлийн цор ганц эргүүлийн ротод үүрэг гүйцэтгэсэн тухайгаа хуучиллаа. Түүний хувьд уулын эргүүлийн ротод үүрэг гүйцэтгэхдээ өндөр, хад асга ихтэй газар нэгээс нөгөөд хөдөлгөөн үйлддэг учраас эрсдэлтэй санагдаж бага зэрэг айдас төрүүлсэн гэнэ. Хийсэн сонголтдоо эргэлзэх үе ч байжээ. "Гэхдээ энэ бүхнийг эргээд харахад олон аавын хөвгүүдтэй, дэлхийн шилдэг дайчидтай мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгээд ирнэ гэдэг бахархалтай, нэр төрийн хэрэг" гэж даруухан омогших дэд хурандаа Б.Болор-Эрдэнийн талаар товчхон өгүүлэхэд ийм.

2008 онд Цэргийн төв эмнэлэгт чих, хамар хоолойн эмчээр томилогдсоноос хойш Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн эмнэлгийн албаны даргаар ажиллаж, БНӨСУ-д энхийг сахиулах ажиллагаанд эмчээр үүрэг гүйцэтгэсэн гээд хос тангарагтан байхын онцлог, утга учрыг нь биеэрээ мэдэрч, ойлгосон ахмад Д.Батбаярын хувьд удам залгасан эмч. Нөгөөтэйгүүр гэр

бүлээсээ ганцаараа цэргийн хүн. Түүний аав Ховд аймгийн Чандмань суманд насаараа Эрүүл мэндийн төвийн дарга хийсэн гавьяат эмч бол ээж нь ч мөн ялгаагүй эх баригч эмч байсан бөгөөд 4000 гаруй хүүхдийг эх барьжээ. Ахмад Д.Батбаяр хэлэхдээ "Нийгэм цаг үеэ дагаад залуусын сэтгэлгээ, манайд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж, аппаратууд эрс шинэчлэгдсэн. Мөн сүүлийн гурав, дөрвөн жилийн дотор Поликлиникийн боловсон хүчний хувьд нэг үе солигдсон гэж хэлж болно. Залуу боловсон хүчин олноор, чанартай бэлтгэгдэж

гурван даргын нүүр үзжээ. Тэрээр "Дэд хурандаа Б.Болор-Эрдэнэ даргын хувьд залуу хүн, алсын бодолтой, төлөв түвшин, түшигтэй санагддаг" гээд залуусынхаа талаар сэтгэгдлээ хуваалцлаа. Ингэхдээ "Манай Поликлиникийн залуусын тодорхой хувь нь БНХАУ болон ОХУ-д академи төгссөн. Ийм ирээдүйтэй залууст мэдээж туршлага хэрэгтэй. Гэхдээ богино хугацаанд их туршлага хуримтлуулах нь лавтай. Тэд биднийг өнгөлж байна" хэмээсэн. Цэргийн эмч гэх нэр хүндийг үүрч явахад түүнд хамгийн их үлгэр дуурайл үзүүлсэн хүн бол Дотрын клиникийн дарга асан,



ТЭДНИЙ ТҮҮХ АРВИН,

ҮЙЛС ӨӨДРӨГ

байгаа нь бидний ололт амжилтын нэг чухал хүчин зүйл. Ахмад үеийнхэн маань ч дөнгөж төгсөөд ирсэн залуусыг "өлгийдөж" аваад сурган дадлагажуулаад мэргэжилд нь дурлуулчихдаг" гэв.

Үнэхээр ч Поликлиникийн эмч, сувилагч, ажилчдын дийлэнх нь залуус. Тэдний төлөөлөл болох хошууч Г.Батмөнх Унгар улсад "НАТО"-ийн эмнэлгийн штабын офицерын сургалтад хамрагдсан бол сэргээн засах тасгийн зүүний эмч Т.Намгар БНХАУ-д мэргэжил, ур чадвараа дээшлүүлэн кинетик зүүний аргаар өвдөлт намдаах инновац нэвтрүүлэхээр зорьж байгаа аж.

"Анх Цэргийн төв эмнэлгийн үүдээр алхан орж байсан үеийг бодвол эмнэлгийн байрны өргөтгөл, тоног төхөөрөмж, боловсон хүчний шинэчлэлүүд хийгдсэн зэрэг олон зүйл өөрчлөгджээ, цаг үетэйгээ хөл нийлүүлэх гээд хэрэндээ л хичээж байна даа" гээд инээд алдах эмэгтэйг хошууч Д.Түмэнцэцэг гэдэг. 1997 онд Анагаах ухааны их сургуулийг төгссөн. Шүүхийн шийдвэрийн байгууллага, Зэвсэгт хүчний 330 дугаар ангид ажилласнаас хойш 10 гаруй жилийг тус эмнэлэгт өнгөрүүлэхдээ

бэлтгэл хурандаа Г.Чулуунбаатар бөгөөд Д.Түмэнцэцэг энэхүү нийтлэлээр дамжуулан түүнд баярласнаа илэрхийлсэн юм.

Дэслэгч Н.Өлзийхутаг 100 жилийн түүхтэй Поликлиникийн нэг эд эс болохынхоо хувьд гэгээлэг сайхан мөрөөдөл тээж явдаг. Тэрээр 2014 онд ЭМШУИС-ийг хүний их эмчээр төгсөж, 2017 онд сэтгэцийн эмчээр мэргэжил дээшлүүлсэн ба 2017-2018 онд Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаад Цэргийн төв эмнэлэгт сэтгэцийн эмчээр томилогджээ. Дэслэгч Н.Өлзийхутаг Цэргийн төв эмнэлэгт ажиллаж хос тангарагтан болсноороо хүний эрүүл мэндийн болон эх орныхоо халдашгүй дархан байдлын манаанд гардаг цэргийн эмч нэг гартаа чангуур, нөгөө гартаа буугаа бариад явах шиг бахархал үгүй гэдгийг маш сайн ойлгож мэдэрсэн аж.

Ийм л итгэл, зүтгэлтэй хамт олон Цэргийн төв эмнэлгийн нүүр царай нь болж, тус эмнэлгээр үйлчлүүлэгчдийн хамгийн ойрын бас энхий "аврагч" нар болдог билээ.

Ц.ЭНХ-ОРГИЛ



Дэд хурандаа Б.БОЛОР-ЭРДЭНЭ



Компьютер эмрай /MRI-н шинжилгээ хийж байна



Хошууч Д.ТҮМЭНЦЭЦЭГ



Иммунологийн шинжилгээтэй танилцлаа



Ахмад Д.БАТБАЯР



Биохимийн шинжилгээ хийгдэв



Дэслэгч Н.ӨЛЗИЙХУТАГ



Шүд эрүүл бол бие эрүүл

Д.ГАНХУЯГ: ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ӨРТӨГСӨД ДАЙНД ЭРСЭДСЭН ХҮНИЙ ТООНООС Ч ИХ БАЙНА

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын ачаалал болон түүнтэй холбоотой зөвлөгөөг танд хүргэхээр Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Д.ГАНХУЯГТАЙ ярилцлаа.

Нийслэлийн аль чиглэлийн зам хамгийн их түгжирдэг вэ? Замын ачааллыг бууруулахад ямар зохицуулалт хийж байгаа бол ...

-Хичээлийн жил эхэлсэн үед Энхтайвны өргөн чөлөө, Нарны зам, Залуучуудын гудамж, Их тойруу, Бага тойруу гээд ихэнх нь ачаалалтай, түгжирдэг. Түгжрэл 07.30 цагаас эхэлдэг болохоор иргэд цагаа зөв төлөвлөж, аль болох эрт гарвал түгжрэхгүй байх боломжтой. Мөн цэцэрлэг, сургууль, ажил тарах үед буюу 18.00 цагаас замын ачаалал эрс нэмэгдэж байгааг та бүхэн сайн мэднэ. Нөгөө талаас иргэдийн ухамсар, замын хөдөлгөөнд оролцохдоо гаргадаг соёлгүй зан үйлээс түгжрэл үүсдэг. Ямар нэгэн байдлаар зохиомол түгжрэлийг үүсгэж, зорчих хэсэг рүү хүн буулгадаг, шалтгаангүйгээр хэт удаан зорчих нь их. Тэр дундаа хувиараа такси эрхлэгчид зөрчил гаргах нь түгээмэл байдаг.

Хүн бүр их, бага хэмжээгээр замын хөдөлгөөнд оролцдог. Тэгвэл зорчигчид хамгийн түрүүнд юуг ухамсарлах ёстой вэ?

-Энэ бол маш энгийн ойлголт. Та замын хөдөлгөөний дүрмийг л зөрчихгүй байж, хөдөлгөөнд соёлтой, хариуцлагатай оролцох учиртай.

Өөрөө замын хөдөлгөөний дүрэм зөрчөөгүй ч осолд өртөх тохиолдол их. Үүнд ямар арга хэмжээ авдаг вэ?

-Зам тээврийн осол болгон дээр Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүй байдаг. Хобуулаа буруутай байх үе ч бий. Замын хөдөлгөөний дүрэм зөрчж байна гэдэг нь ямар нэгэн эрсдэл дагуулж байна л гэсэн үг. Тиймээс Замын хөдөлгөөний дүрэм зөрчихийг энгийн байдаг л зүйл шиг бодож огт болохгүй. Иргэн та өдөр тутам алдаа дутагдал бүү гаргаарай. Хүн бүхэн замын хөдөлгөөний дүрмээ ягштал биелүүлж, бусдад хүндрэл учруулж болохгүй. Үүнийг л иргэд ухамсарлах хэрэгтэй.

Зам тээврийн ослоор амь насаа алдаж байгаа иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа шалтгааныг юу гэж харж байна вэ?

-Энэ бол харамсалтай ч бодит үнэн юм. Хамгийн эхэнд ачаалал их байна. Үүн дээр нэмэгдээд хурд хэтрүүлэх, дүрэм зөрчдөг байдал ч мөн ослоор төгсөж байгаа. Мөн "хөнгөмсгөөр найдах" гэдэг хуулийн хэллэг бас байгаа. Энэ нь урьдчилан таамаглаагүй байхыг хэлж байгаа юм. Жишээлбэл, жолооч аюул саадыг олж харсан хугацаа, хажуу тийшээ дарах уу, тоормослох уу зэргийг тархиндаа боловсруулах хэрэгтэй. Самбаачлах хугацаа, тээврийн хэрэгслийн тоормосны механик ажиллах хугацаа зэрэг үүнд багтана. Жолооч болгон л тооцоолох хэрэгтэй. Үүнийг тооцоолохгүйгээс осолд өртөх эрсдэл нэмэгдэж байна. Мөн нэмэгдээд энэ хөдөлгөөнт гар утасны хэрэглээ ихэссэнээс анхаарал сарниж байгаа асуудал бас бий. Монгол Улсад амь насаа алдаж байгаа хүмүүсийн шалтгааныг жагсааж үзвэл нэгдүгээрт зүрх судасны өвчин, хоёрдугаарт хорт хавдар, гуравдугаарт зам тээврийн осол орж байна. Авто замын ослоор амиа алдаж байгаа хүний тоогоор Монгол Улс 180 орноос 120-д орж байх жишээтэй.

Мөн энд өөр нэг жишээ дурдъя. Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад манай цэргийнхэн үүрэг гүйцэтгэдэг. Тэнд дайны жилүүдэд жилд 4000 хүн амь насаа алддаг.33 сая

хүн амтай улстай харьцуулахад гурван сая гаруй хүн амтай манай улс жилд 500 гаруй хүнээ зам тээврийн ослоор алдана гэдэг бол жилд нас барсан хүний тоо тухайн дайнтай орноос давсан үзүүлэлт. Энэ бүгд юуг хэлэх вэ гэвэл, зам тээврийн осол нь аюултай хэмжээнд байгаагийн илрэл юм. Хүн өөрт тохиолдоогүй бол үүний хэцүүг, зовлон шаналлыг мэдэрдэггүй юм. Тиймээс энэ бүгдээс сэргэмж авч, хамгаалах бүсээ тогтмол зүүж замын хөдөлгөөндөө дүрмийн дагуу оролцох үүрэгтэй. Энэ нь эргээд миний эрүүл мэнд, амь нас гэдгээ л ухамсарлах асуудал байгаа юм.

Дүрэм зөрчөөд л осол гаргаад л байдаг нөхөд байгаа. Энд ямар арга хэмжээ авах вэ?

-Монгол Улсад хариуцлагын тогтолцоо сул. Үүнээс үүдэлтэй. Тиймээс үүнийг бодлогын хэмжээнд шийдэх асуудал гэж хардаг. Торгуулиас айдаггүй хүмүүс байна. Зарим улс оронд замын хөдөлгөөний дүрмийн нэг л зөрчил дээр хагас сарын цалингаар нь торгож байхад манай улсад замын

Монгол Улсын хэмжээнд 2019 онд Зам тээврийн ослын дуудлага 77444, зам тээврийн осол 25302, амь насаа алдсан хүн 561, хүнд гэмтэж бэртсэн хүний тоо 3790, хүүхэд өртсөн осол 745, амь насаа алдсан хүүхэд 59, учирсан хохирол 24 тэрбум 308,2 сая төгрөг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1276.

Эдгээр тоо баримт бидний чихэнд хэдийнээ дасал болж дүлий дүмбэ оргин тоохоо байсан мэт. Та ахиад нэг дээрх тоог хараарай, бас нэгийг бодоорой. Ганцхан жилийн хугацаанд 561 эрдэнэт хүний амь нас зам тээврийн ослын улмаас эрсэдсэн нь олон хүний багтаамжтай онгоц таван удаа сүйрсэнтэй, Халхын голын байлдаанд амь эрсэдсэн хүний тоог гурав дахин нэмсэнтэй адил тэнцэх аж. Мөн эдгээрийн хойно хэчнээн олон айлын амьдрал оронгоороо өөрчлөгдөж, хэчнээн олон айл хазацлын зовлонг амсаж, хэчнээн олон айл үгүйрэн хоосорч, харамсал дунд өдөр хоногийг өнгөрүүлж байдаг нь тодорхой. Болдог л юм гэж хэнэггүй царйлалгүй уншигч та ч бас энэ тоог бууруулахад маш том оролцоотойгоо ухаарч замын хөдөлгөөний болон явган зорчигчийн дүрмээ баримтлан замын хөдөлгөөнд оролцох нь хамгаас чухал юм. Тэгвэл бид хамгийн түрүүнд юунд анхаарах хэрэгтэй вэ? Мөн болзошгүй эрсдэлээс хэрхэн сэргийлэх вэ? Замын хөдөлгөөний соёл, явган зорчигчийн соёлоо хэрхэн дээшлүүлэх вэ гээд олон олон асуудлыг энд тавих хэрэгтэй юм.

хөдөлгөөний дүрмийн таван заалт зөрчөөд нэг өдрийн цалингийн хагастай тэнцэх хэмжээний мөнгөөр торгодог байх жишээтэй. Зөрчил буурахгүй байгаа нь ердөө л үүнтэй холбоотой.

Эдгээр осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн байгууллагаас ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байна вэ?

-Жилийн төлөвлөгөөний хүрээнд нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай нь уялдуулан тогтмол явуулдаг. Тухайлбал, өнгөрсөн жил "Яараад яах вэ", "Дураараа биш дүрмээрээ" гэх мэт олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Тухайн арга хэмжээ хэрэгжих үеийн осол, зөрчил өмнөх жилийн тухайн үетэй харьцуулахад 31-64 хүртэлх хувиар буурсан тоон үзүүлэлт бий. Мөн баяр ёслолын үеэр тээврийн цагдаагийн бие бүрэлдэхүүн бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилладаг. Хамгийн ойрын жишээ дурдахад, Цагаан сарын баярын гурав хоногт 10-18 хүн амь насаа алддаг. Учир нь энэ үеэр бүх тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож, хотоос хөдөө, хөдөөнөөс хот руу чиглэсэн хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой.

Үр хүүхдээ зам тээврийн осол, гэмтлээс сэргийлэх нь эцэг, эх бидний үүрэг. Та энд тал дээр зөвлөгөө өгнө үү?

-Зөвлөгөөнийхөө өмнө би нэг баримт дурдъя. Өнгөрсөн жил зам тээврийн ослын улмаас 59 хүүхэд амь насаа алдсан. Энэ бол хоёр анги дүүрэн хүүхэд

гэсэн үг. Зүрх зүсэгдэм тоо байгаа биз. Эдгээр хүүхдүүдийн дийлэнх нь хөдөө, орон нутагт бууруу тээвэрлэлтээс болон ганцаараа явж байх үедээ зам тээврийн осолд өртсөн. Тиймээс эцэг, эхчүүд өөрсдөө үлгэрлэх хэрэгтэй. Мөн тээвэрлэх явцдаа хүүхдийнхээ аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Арваас доош насны хүүхдийг хамгаалалтын суудалд нь суулгаж хэвшүүлэх, хэрэв байхгүй бол арын суудал дээрээ суулга. Ер нь боломжгүй зүйл гэж үгүй. Үр хүүхдээ тань үнэтэй зүйл гэж үгүй. Осол, гэмтлийн 95 хувь нь томчуудаас болсон байдгийг энд бас нэмж хэлье.

Сүүлийн асуулыг танд үлдээе ...

-Манай байгууллага Тээврийн цагдаагийн албаны сүлжээтэй холбогдсон байдаг. Энэ дагуу цэргийн алба хаагчид автомашинтай зам тээврийн осол, зөрчил гаргасан тохиолдол бүрийг мэдэх боломжтой болж байгаа юм. Ингэснээр ЗХЖШ болон харьяа командлагд нь тухайн мэдээллийг хүргүүлж, үүнээс урьдчилан сэргийлэх тодорхой ажил, арга хэмжээ зохион явуулна гэсэн үг.

Үүгээр бидний яриа дуусаагүй бөгөөд дэслэгч Д.Ганхуяг цааш нь үргэлжлүүлэн Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх нэн тэргүүний зөвлөмжүүдийг уншигчдадаа хүргэсэн юм.



БУСДАД ХҮНДРЭЛ УЧРУУЛЖ, ЗОХИОМОЛ ТҮГЖРЭЛ ҮҮСГЭЖ БОЛОХГҮЙ

Нийслэлд нэг сая орчим тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн. Үүний 900 мянга гаруй нь автомашин. Эдгээрийн 400-500 мянга нь нийслэлд замын хөдөлгөөнд идэвхтэй оролцдог бөгөөд тээврийн цагдаагийн алба хаагчдын бие бүрэлдэхүүн, орон тоо хүрэлцэхгүй байгаагаас улбаалж тэр бүр ачаалалтай, элдэв асуудал гарсан газар бүрт хүрч ажилладаггүй гэсэн үг юм. Тиймээс бид болзошгүй осол, өдөр тутмын түгжрэл зэргээс хэрхэн сэргийлж чадах вэ гэвэл бусдад хүндрэл учруулалгүй замын хөдөлгөөнд оролцох явдал юм. Бусдад хүндрэл учруулахгүй байна гэдэг нь замыг зогсоол болгож ашиглахгүй байх, зам дээр тээврийн хэрэгслээ орхижгүй байх, дураараа биш дүрмээрээ явах, гэрлэн дохио болон замын тэмдэг, тэмдэглэгээг ягштал биелүүлэх зэрэг багтана. Та дээрх зүйлсийг дүрмийн дагуу хийснээр зохиомол түгжрэл үүсгэхгүйгээс гадна зам тээврийн осолд өртөх эрсдэлээс 80 хувь хамгаалагдаж байдаг юм. Мөн иргэд замын хөдөлгөөнд соёлтой оролцож, бусдыгаа хүндэлдэг, ухамсартай байж чадвал түгжрэлийг 25 хувиар бууруулах боломжтой.

СОГТУУГААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОЖ АМЬ НАС, ЭД ХӨРӨНГӨӨРӨӨ ХОХИРОХ ТОХИОЛДОЛ ИХ БАЙНА

Зам тээврийн осол, гэмтлийн багагүй хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байх үед үйлдэгдсэн байдаг аж. Энэ төрлийн зөрчил буурахгүй байна. Тухайлбал, нийслэлийн хэмжээнд хүн гэмтсэн дуудлага тайван үед хоногт 8-10, ачаалалтай үед 25-30 гаруй ирдэг байна. Мөн явган зорчигчид ч үүнд хамаатай байдаг. Тэд мөн л согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгслийн урдуур гүйж, амь насаа эрсдэлд оруулдаг. Дэлхий дээр 48 секунд тутамд нэг хүн согтуу жолоочийн хохирогч болж байна. Иймээс оюун ухаант хүн мөн бол та согтуурсан үедээ жолооны ард суухаас эрс татгалзах хэрэгтэй.

МОТОЦИКЛИЙН УЛМААС АМЬ НАСАА АЛДСААР БАЙХ УУ?

Манай улсад зам тээврийн ослоор жилд 500-600 хүний амь нас хохирч, 1000-1200 хүн хүндэтэр болон хүнд гэмтэж, бэртэж байна. 2019 оны байдлаар 1004 хүн хүндэтэр, хүнд гэмтэж, 561 хүн амь насаа алдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмтсэн хүн 11,9 хувиар, нас барсан хүний тоо 5,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт амь насаа алдсан хүмүүсийн 20,5 хувь буюу 110 нь мотоциклтэй хөдөлгөөнд оролцсон гэх судалгаа байна. Судалгаагаар мотоцикл жолоодож байгаа иргэд нь жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэхгүй, хамгаалах малгай өмсөөгүй, жолоочийн албан журмын даатгалд даатгуулаагүй, мөн улсын бүртгэлд бүртгүүлж улсын бүртгэлийн дугаар аваагүй, техникийн хувьд бүрэн бус, эвдрэл, гэмтэлтэй мотоциклтэй замын хөдөлгөөнд оролцож амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох явдал буурахгүй байна.

ХУРД ХЭТРҮҮЛБЭЛ ҮХЭЛ

Бүртгэгдэж буй зам тээврийн ослын дийлэнх нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалдаг бөгөөд бүртгэгдсэн ослын багагүй хувь нь тээврийн хэрэгслийн хурдаа тохируулаагүйгээс шалтгаалж гарсан байна. Хурд тохируулаагүйгээс бүртгэгдсэн зам тээврийн ослыг аймаг, дүүргээр нь авч үзвэл Төв, Өмнөговь, Дундговь аймагт, нийслэл хотод Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн алслагдсан замуудад хамгийн их бүртгэгджээ.

Он гарсаар эхний хоёр сарын байдлаар гэхэд улсын хэмжээнд хурд тохируулаагүйгээс шалтгаалан 150 гаруй осол бүртгэгдсэн нь нийт ослын 3,8 хувийг эзэлж байх боловч учирсан хохирол, хүний эрүүл мэнд ноцтой байдлаар гэмтэж, амь насаа алдах тохиолдол нь өндөр байна.

Хурд тохируулаагүй нь олонх улс орны зам тээврийн осол гарах үндсэн хүчин зүйл болдог ба энэ нь шинэ жолооч нартай холбоотой. Хурдыг нэг км/цагаар л бууруулахад зам тээврийн осол 4-5 хувь буурдаг гэж олон улсад үздэг. Автомашинаар хурд багатай явах тусам ослын үед хохирол бага учирдаг тул жолооч та хурдаа хасаж, тогтоосон хязгаарыг мөрдөж хөдөлгөөнд оролцоорой.



ЗУРГААДУГААР ҮЕИЙН СӨНӨӨГЧ ОНГОЦНЫ ТЕХНОЛОГИЙН БОЛОМЖУУД НЬ УРАН ЗӨГНӨЛ БИШ

Зэвсэгт хүчнийхээ хөгжлөөр тэргүүлдэг улс орнуудад Батлан хамгаалах салбарын технологийн судалгааны нэгэн гол хэсэг нь байлдааны сөнөөгч онгоцны хөгжил байдаг. Өнөөдрийн байдлаар дэлхийн хэд хэдэн улс хамгийн орчин үеийн буюу тавдугаар үеийн ийм төрлийн онгоцыг ашиглаж байна.

Shinshin", Пакистан "Project AZM" зэрэг тавдугаар үеийн онгоцыг зэвсэглэлд нэвтрүүлэхээр хөгжүүлж байна. Одоогийн байдлаар ийм төрлийн онгоцны хөгжилдөө хамгийн их төсөв зарцуулж, судалгаа шинжилгээ явуулдаг нь АНУ, ОХУ юм. АНУ-ын хувьд ирээдүйд хэдхэн жилийн дотор зургаадугаар үеийн байлдааны нисэх онгоц үйлдвэрлэхээ

онгоцыг зохион бүтээх ажлыг хурдасгаж, зарим тавдугаар үеийн онгоцны үйлдвэрлэлийг бууруулан дараагийн үеийн онгоц үйлдвэрлэх зардалд анхаарлаа хандуулах хэрэгтэй" гэв. Тэр бээр цааш нь "Орос, Хятад улс тавдугаар үеийн онгоцнуудыг ашиглаад эхэллээ. Хэрвээ тус хоёр улс зардал өндөртэй тавдугаар үеийн онгоцуудыг олноор үйлдвэрлээд эхэлбэл АНУ 2020 оны дунд үе гэхэд агаарын орон зай дахь ноёрхлоо алдана" гэжээ. Гэтэл АНУ-ын зарим эрх баригчид "Заавал зургаадугаар үеийн байлдааны онгоц зохион бүтээх шаардлагагүй. Маш өндөр өртгөөр бүтсэн тавдугаар үеийн байлдааны онгоцнуудын юу чадахыг одоогоор хэн ч хараагүй байгаа" гэж үзэж байгаа ажээ.

Хэдий зарим улс төрч ингэж үзэж байгаа ч АНУ-ын нисэх онгоц үйлдвэрлэгч аварга компаниуд болох "Boeing", "Lockheed Martin", "Northrop Grumman" шинэ үеийн сөнөөгч онгоц зохион бүтээх "F/A-XX" төсөл дээр хамтран ажиллаад эхэлжээ. 2030 он гэхэд төслийн эхний шатанд бүтээгдсэн онгоцыг дэлхий нийтэд танилцуулахаар зэхэж байна. Онгоцны их биеийн гадаргууг "ухаалаг" байхаар төлөвлөж байгаа бөгөөд дайсанд үл үзэгдэх, гаднаас ирж байгаа аюулыг электрон-магнетик технологийн тусламжтайгаар устгах зэрэг техникийн шинэ шийдлүүд багтжээ. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан, лазерын зэвсэглэлээр тоноглогдсон байх юм. Хамгийн гол нь удирдлагын системийн найдвартай байдлыг "Northrop Grumman" компани хариуцан ажиллаж, нисгэгчид онгоцны болон орчны мэдээллийг хялбар бөгөөд нарийвчлалтай өгөх, үүссэн цагийн байдлын үед авч болох арга хэмжээний хувилбаруудыг богино хугацаанд бэлдэж өгөх, алдаагүй шийдвэр гаргах нөхцөлөөр хангах технологийг хөгжүүлэхээр ажиллаж байгаа ажээ. Зэвсгийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар байлдааны онгоцонд лазерын зэвсэглэл нэмэгдвэл гэрлийн хурдаар байг устгах нөхцөл бүрдэх




учир хамгаалалтын системийг үндсээр нь өөрчлөх шаардлага тулгарна гэдгийг анхааруулж байна.

Харин ОХУ-ын Агаар-сансрын хүчин нисэх онгоц үйлдвэрлэгч "Микоян" компанитай хамтран 5++ эсвэл зургаадугаар үеийн гэж нэрлэж болохоор "МиГ-41" сөнөөгч онгоцыг зохион бүтээх төслийг эхлүүлээд байна. Нислэгийн алслалтыг уртасгаж, зориулалтыг нь нэмэгдүүлж, дуунаас хэт хурдан пуужингийн технологид суурилсан тийрэлтэт хөдөлгүүртэй байхаар төлөвлөж байгаа юм. 2016 оны 7 дугаар сараас тус онгоцыг зохион бүтээх төслийг эхлүүлсэн тухай албан бус мэдээ цацагдаж эхэлсэн. Мэргэжилтнүүдийн таамаглаж байгаагаар 2020 оны сүүлчээр гэхэд тус онгоцны туршилтын нислэгийг эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа ажээ. 2019 оны сүүлчээр "МиГ-41"-ийн дизайн батлагдсан бөгөөд судалгааны ажил нь ч мөн 2020 он гэхэд бүрэн дуусах төлөвлөгөөтэй байна.

зохион бүтээж байгаа гэнэ. Энэ талаар И.Тарасенко нэмж хэлэхдээ "МиГ-41" бол шинжлэх ухааны уран зөгнөлт зохиол биш. Мэдээж бидний бүтээхээр зорьж буй технологийн боломжууд нь хүн жолоодох боломжгүй мэт санагдаж байгаа ч бид энэ талд тооцоо судалгаа багагүй хийсэн. Тийм учраас онгоцыг нисгэгчтэй болон нисгэгчгүй гэсэн төрлөөр хөгжүүлж байгаа" гэсэн юм. ОХУ-ын Радио-электроник техник группийн захирал М.Владимир "ТАСС" агентлагт өгсөн ярилцлагадаа "Зургаадугаар үеийн байлдааны нисэх онгоц "МиГ-41"-ийн шинжлэх ухааны болоод техникийн хөгжүүлэлт, тооцоо, судалгаа зэргийг аль хэдийн эцсийн байдлаар төлөвлөчихсөн. Одоо зэвсэглэл, хамгаалалт, хөдөлгүүрийн систем зэргийг хөгжүүлэх ажил явагдаж байгаа. "МиГ-41"-ийн зэвсэглэлээс дурдвал электро-магнетикийн их буутай, радио-фотоникийн радарын шинэ үеийн системтэй байна" гэжээ.

Хоёр их гүрний зургаадугаар үеийн байлдааны онгоц бүтээх өрсөлдөөн одоогийн байдлаар ийм түвшинд явж байна. Тэд уг төрлийн онгоцыг 2030 он гэхэд зохион бүтээх гэдэг төлөвлөгөөтэй байгаа нь дээрх баримтуудаас харагдлаа. Хэрвээ зургаадугаар үеийн онгоцны төсөл амжилттай хэрэгжвэл 10 хүрэхгүй жилийн дотор дэлхийн улс орнуудад байлдааны нисэх онгоцны технологийн нэгэн шинэ үе ирэх нь байна.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ



үзэгдэх, өндөр цэц, хурд, маневр, автоматжуулалт, байршил тогтоох, тагнуулын мэдээ цуглуулах төхөөрөмж, зэвсэглэл зэрэг технологиудын хамгийн сүүлийн хувилбаруудыг өөртөө шингээснээр тавдугаар үеийн ангилалд тухайн байлдааны сөнөөгч онгоц багтдаг аж. Дэлхийн улсуудаас хамгийн түрүүнд агаарын цэргийн хүчиндээ ийм төрлийн онгоцтой болсон нь АНУ юм. "Lockheed Martin" буюу тус улсын цэргийн зориулалттай нисэх онгоц үйлдвэрлэгч хамгийн том компани анх 2005 онд "F-22 Raptor", 2015 онд "F-35 Lightning II" онгоцыг тус тус зэвсэглэлд шилжүүлж байв.

зарласан. Тус улсын Агаарын цэргийн хүчний Төрийн нарийн бичгийн дарга Майкл Доунли хэлэхдээ "Агаарын цэргийн хүчин зургаадугаар үеийн байлдааны нисэх онгоцыг зохион бүтээх ажлыг түргэвчлэх хэрэгтэй байна. Бид "F-22", "F-35" зэрэг тухайн ангилалдаа тэргүүлэгч онгоцуудыг зохион бүтээсэн туршлага, үйлдвэрлэлийн бааздаа тулгуурлан тавдугаар үеийн онгоцны хэд хэдэн дутагдлыг засаж, шинэ төрлийн онгоц бүтээх төслийг амжилттай эхлүүлээд явж байна" гэж "The National interest" сэтгүүлд өгсөн ярилцлагадаа хэлжээ. Зургаадугаар үеийн байлдааны нисэх онгоцонд тавигдах үндсэн шаардлагын нэг нь агаар-сансрын орон зайд үүрэг гүйцэтгэх чадвар байх ажээ. Тус улсын Батлан хамгаалахын сайд асан Роберт Гэйтс хэлэхдээ "F-22 Raptor" онгоцны үйлдвэрлэлийн зардал маш өндөр. Иймд зургаадугаар үеийн байлдааны

Харин 2017 онд БНХАУ-ын Ардын Чөлөөлөх Армийн нисэх хүчин "Chengdu J-20" онгоцыг дэлхий нийтэд танилцуулсан бол ОХУ 2018 онд "Су-57" онгоцыг зэвсэглэлд шилжүүлэн Сирийн дайнд "шандас"-ыг нь сориод амжсан. Япон улс "Mitsubishi X-2

(Түрүүч нь 5 дахь дугаарт)

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

СТАНДАРТЧИЛАЛ БА СТАНДАРТЫН ҮНДСҮҮД

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний стандартчилал ба стандартын мэдлэгийг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр "Соёмбо" сониноор цуврал нийтлэлийг хүргэж байна.

1.4. Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо: байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн байгууллага,



Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо нь Засгийн газар, Стандарт хэмжил зүйн газар, Стандартчиллын техникийн хороодын нарийн бичгийн дарга, Стандартчиллын техникийн хороо, дэд хорооноос бүрдэнэ.

үйлдвэрлэгч, хэрэглэгчтэй хамтран уялдуулан зохицуулж ажилладаг. Техникийн хороод нийт 800 гаруй гишүүнтэй. Үүнээс: 52 хувь нь төрийн байгууллагын төлөөлөл, 14 хувь нь төрийн бус байгууллагын төлөөлөл, 23 хувь нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, 13 хувь нь хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдэнэ.

Монгол Улсын Засгийн газар, Стандарт хэмжил зүйн газар нь олон улсын стандартчиллын байгууллага, Европын холбооны стандартчиллын байгууллагатай хамтран ажиллаж удирдамж, зөвлөмжийг мөрдлөг болгон олон улсын болон бус нутгийн стандартыг үндэсний болгох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Монгол Улсад "Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо" MNS 1-1:2006 "Техникийн ажиллагааны дүрэм", MNS 1-2:2006 "Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм" суурь стандартыг мөрдлөг болгоно.

Монгол Улсад үндэсний стандартчиллын 60 гаруй техникийн хороо, дэд хороо үйл ажиллагаагаа төрийн байгууллага, төрийн бус

Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол Улсын хуульд "Стандартчилал нь бүтээгдэхүүн, үйлчилгээний

харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагаа" гэж тодорхойлсон.

Өөрөөр хэлбэл, стандартчилал нь тодорхой салбарт оролцогч, сонирхогч талуудад бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний нийцтэй эдийн засгийн үр ашгийг байдалд хүргэх, давтан хэрэглэх, ашиглалтын нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангах, зорилго, дүрэм, журамтай үйл ажиллагааг тогтоох явдал юм.

Стандартчилал нь шинжлэх ухаан, техникийн ололт, тэргүүн туршлага, ирээдүйн чиглэл, хөгжил дэвшил дээр үндэслэгдэнэ. Стандарт нь олон төрлийн байдаг учир стандартчилах объектыг бүлэглэж хуваах, түгээмэл дүрэм тогтоох боломжгүй.

Тухайлбал, бүтээгдэхүүний өөр өөр талуудын (жишээлбэл, үйлдвэрлэгч, баталгаажуулалтын байгууллага, хуулийн байгууллага г.м) ашиг сонирхолд хамаарах асуудлыг тодорхой ялгаж, баримт бичгийн хэсгүүдийг салангид байдлаар гаргавал зохино. Шинж чанар нь сайн ялгагдахуйц тус тусдаа баримт бичигтэй байх шаардлагатай.

1.5. Стандарт ба стандартчилах объект /зүйл/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол Улсын хуульд "Стандарт нь тодорхой хүрээнд хэм хэмжээг бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан сонгон хэрэглэх баримт бичиг" гэж тодорхойлсон.

Стандарт гэдэг нь хэм хэмжээ, загвар гэсэн утга бүхий англи үгнээс

гаралтай. Стандарт нь аливаа зүйлийг харьцуулахад хэрэглэгдэг жишиг бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний харилцааг зохицуулагч нь болдог.

"MNS" улсын стандартын тэмдэглэгээг "MN"-Монгол Улс, "S"-стандарт гэж латин үсгээр товчлон тэмдэглэхээр олон улсын нэрийн код "ISO-3166" стандартыг үндэслэн тогтоосон.

Стандартчиллах объектод материаллаг зүйлүүд /бүтээгдэхүүн, эх хэмжүүр, дээж бодисууд/ болон материаллаг бус ажил, үйлчилгээ хамаардаг, тэдгээр нь арга зүй, зохион байгуулалт, техникийн шинж чанар, хэрэглэх арга, нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээ, норм, дүрэм, тавигдах шаардлага нь өөр өөр байдаг.

1.6. Стандартчиллах зүйлүүд:

- > Шинжлэх ухаан, техникийн нэр томьёо, тэмдэг тэмдэглээ, тодорхойлолт,
- > Физик хэмжигдэхүүний нэгж;
- > Улсын эталон, физик хэмжигдэхүүний нэгж, баталгаажуулалтын бүдүүвч;
- > Хэмжих хэрэгслийг баталгаажуулах арга, хэрэгсэл;
- > Үнэн зөв хэмжих норм;
- > Хэмжил хийх аргачлал;
- > Материал болон бодисын бүрдэл, шинж чанар, загварын стандартын шаардлага;
- > Ашиглаж байгаа автомат удирдлагын систем, бүтээгдэхүүний хэлбэр, баримт бичгийн системийг ижилтгэх.

1.7. Стандартчиллах зүйлд тавигдах шаардлага:

Стандартчиллах зүйл нь олон удаа хэрэглэх шинжлэх ухаан, техник, үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, барилга, тээвэр холбоо, соёл урлаг, эрүүл мэндийг

хамгаалах, цэргийн хэрэгт болон бусад салбарт ашиглагдах гадаад худалдааг хамарсан өргөн хүрээтэй байна. Үүнд:

-Стандартад тавигдах шаардлага нь үйлдвэрлэл, шинжлэх ухаан, техникийн тэргүүлэх түвшинд хүрсэн, зохион бүтээлт нь туршигдсан, шинжилгээ судалгааны үр дүнд үндэслэгдсэн, олон улсын стандартад тохирох олон улсын стандартын байгууллагын зөвлөмжийг тусгасан байх;

-олон улсын стандартчиллын байгууллагын зөвлөмж болон үндэсний практик үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа стандартуудыг үндэслэн шинээр боловсруулах, стандартад үйлдвэрлэлийн түвшнийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, дэвшилтэт техник технологи хэрэглэх, шинэ норм тогтоох шаардлага тавигдана;

-стандартчиллын үр дүнг дээшлүүлэх зорилгоор стандартчиллах зүйл, үйлдвэрлэл, үйл ажиллагааг шинж чанараар нь бүлэглэн нэгтгэсэн стандартчиллыг хэрэглэдэг. Энэхүү нэгдсэн стандартчилал нь стандартчиллах зүйлийн үйл ажиллагаа, цаг хугацааг зохицуулах, харилцан уялдаа холбоотой үзүүлэлтүүдийг тохиролцоо замаар сонирхогч байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг бүрэн хангахад оршино;

-нэгдсэн стандартчиллыг төсөл, хөтөлбөр боловсруулах, бүтээгдэхүүн, нэгж, эд анги, материал, түүхий эд, техник хэрэгсэл болон үйлдвэрлэлийн арга, зохион байгуулалтыг хамруулан тогтооно.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)
Бэлтгэл хурандаа Ц.ДОРЖХҮҮ

“Соёмбо” сонины редакцияас хүндэт зочдыг урьж, сар тутамд уншигчдаа зориулан редакцын уулзалт зохион байгуулдаг. Энэ удаад “Жавзандамба хутагт төв”-ийн багш-орчуулагч С.ТҮВДЭНЦЭРЭНГ урьж, буддын шашны мөн чанар, онцлогийн тухай ярилцлаа.



С.Түвдэнцэрэн:

НЭГ ЗОВЛОНГООС НӨГӨӨ ЗОВЛОНД ШИЛЖИХ ТОРГОН МӨЧИЙГ БИД ЖАРГАЛ ГЭЖ ЭНДҮҮРДЭГ

Манай сонины редакцияд хүрэлцэн ирсэн танд баярлалаа. Та төвийнхөө үйл ажиллагааны талаар дурдана уу?

-Манай төв нь ямар нэгэн сүм, хийд биш бөгөөд бурхан багшийн сургаал, түүний гүн ухааныг дэлгэрүүлэх зорилготой төрийн бус байгууллага гэж ойлгож болно. Тийм ч учраас VIII Богд Жавзандамба хутагтын нэрээр байгууллага нэрлэж, нийгмийг соён гэгээрүүлэх, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхүүд болон малчдад туслах зэрэг хүмүүнлэгийн ажлыг зохион байгуулж байна. Мөн хорих ангиудаар явж, хүмүүжигчидтэй сургалт зохион байгуулж, тэдний сэтгэл зүйг засахыг хичээдэг. Хоригдуудад үйлийн үрийн тухай ярихаар өөрт нь гэмших сэтгэл төрж, хэн нэгэнд буруу өгч, өширхөж байсан сэтгэл нь тайлагддаг. Ийм байдлаар бурхны шашнаар дамжуулан хүмүүст аз жаргал, гэрэл гэгээ бэлэглэхийг зорин ажиллаж байна. Гэхдээ энэ бол буддын шашны зөвхөн өнгөц чанар нь гэдгийг ойлгох хэрэгтэй. Цаад мөн чанартаа бол хүмүүсийг гэгээрүүлэх, орчлон хорвоогийн мөн чанарыг таньж ухаарах зэрэг маш нарийн философитой.

Буддын тэр дундаа шарын шашны онцлогийн тухайд Та юу хэлэх вэ?

-Хүмүүс буддын шашнаас ид шид хүлээх хэрэггүй. Зарим хүн шалгалтдаа ерөөс бэлдээгүй байж лам дээр ирээд аргалж өгөхийг хүсдэг. Энэ бол туйлын буруу. Гэхдээ хүн бүр бурхны шашны философийг нь ойлгох албагүй. Тийм боломж ч байхгүй. Зарим хүн сүжгээр юмсыг хүлээж авдаг шүү дээ. Өөрөөр хэлбэл, айдсаар нь дамжуулан тухайн хүнийг нуглийг тэвчих сэтгэл зүйтэй болгодог нь шашны бас нэгэн онцлог. Тийм болохоор шашны зан үйл яалт ч үгүй байх ёстой. Бурхан багш өөрийнхөө сургаалыг хүн бүрийн оюун ухааны хэмжээнд нь тааруулж айлдсан байдаг. Үүнээс шалтгаалж бурхан багшийн үзэл 18 задарсан. Гэхдээ онолын хувьд жаахан зөрсөн ч цаад утга санаа нь нэг юм. Буддын шашин нь их, бага хөлгөний судартай.

Бага хөлгөн дэлгэрсэн газрууд болох Зүүн өмнөд Азийн орнуудад буддын шашны бясалгал тал нь хөгжсөн. Цагаан хоол идэж, хүний хийг хөдөлгөн оргүй хоосны бясалгалд автуулж тайвшруулдаг. Ийм талын бясалгалыг их хөлгөнд төдийлөн дэлгэрүүлээгүй. Их хөлгөн дэлгэрсэн хэд хэдэн улс байдгаас зөвхөн Төвөд, Монгол хоёр нь нууц тарнийн ёсыг дээд цэгт нь хүртэл хөгжүүлсэн юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад

бага хөлгөний ёс байхгүй гэсэн үг. Хятад, Япон, Солонгос улсад их хөлгөн дэлгэрсэн ч тарнийн ёсны доод шатыг л хөгжүүлсэн. Тийм учраас монголчууд бид шарын шашнаа хайрлан хамгаалж, хүндэтгэж явах учиртай.

Буддын шашны нийгэмд үзүүлэх ач холбогдлын талаар дурдвал ...

-Бурхны шашны зорилго нь хүнийг энэ насанд нь амар амгалан байлгах биш юм. Хойд насанд нь сайн байлгах нь анхны зорилго бол хорвоогийн асуудлуудад цэг тавих нь хоёр дахь, харин хорвоо ертөнцийн төлөө гэгээрэх нь эцсийн зорилго юм. Тийм учраас буддын шашинд итгэсэн хүмүүс хойд насаа бодож холыг харж амьдардаг. Тэгснээр амьдралын янз бүрийн асуудлуудад төдийлөн барьц алдаад байхааргүй болдог. Хүний нас гэдэг чинь орчлонгийн хязгааргүй цаг хугацааны хувьд өчүүхэн ялгалаад өнгөрөх төдий зүйл гэдгийг ухаарах ёстой. Үүнийг ойлгосон хүмүүс өнөөдрийн ашгийн төлөө хэн нэгнийг хохироохгүй бөгөөд энэ насны хоромхон жаргалын төлөө хойд насаа золиослохгүй гэсэн үг юм. Тиймээс энэ насны бүтэн хоолыг өгсөн ч эх орноосоо урвахгүй хэмжээнд сэтгэл зүй бэлтгэгдэнэ гэсэн үг. Энэ мэт буддын шашны хувь хүнд үзүүлэх эерэг нөлөө маш их. Ер нь монголчууд нэг шашнаа гол болгон баримталж байх нь өлзийтэй. VIII Богд Жавзандамба хутагт хааны үед монголчуудын оюун санаа, зоригийг нэгтгэсэн нь шашин байсан.

Шашны ном судрыг заавал төвөд хэлээр унших ёстой юу?

-Буддын шашны номын үг, утга уран тансаг бөгөөд яруу байдаг. Үйлчлэх хүч нь ч төвөд хэл дээрээ илүү. Бурхан багшийн их хөлгөний номлол нь санскрит, бага хөлгөн нь пари хэл дээр анх бичигдсэн. Тус хоёр судрыг ямар ч утгын гажилтгүй эх хэлнээ буулгасан нь гагцхүү төвөдүүд юм. Тэд Соронзонгомбо хааныхаа үед бичиг, үсэгтэй болохоор хиндү бичгээс төвөдөд хэрэглэдэггүй авиануудыг хасаад дөрвөн эгшиг, 30 гийгүүлэгчтэй үсэг зохиосон. Ингээд их хөлгөний судрын бүх утгыг алдагдуулалгүй шууд хөрвүүлж чадсан байдаг. Монголчуудын хувьд ч мөн хиндү, санскрит, төвөд хэлийг яг авиагаар нь буулгахаар анхдугаар Богд Занабазар соёмбо үсэг зохиож байсан түүхтэй. Төвөд хэлээр ном уншихад төвөд хүмүүс ойлгодоггүй. Учир нь Төвөдийн

ард түмний дотор номын хэл гэж тусдаа нэгэн хэл үүссэн. Тэр байтугай Далай ламыг номоо айлдаж эхлэхэд бид нар өөрсдийн чадах хэмжээнд хүртэл ойлгоод доод зиндаанаасаа эхлэн хаягдаж эхэлдэг. Учир нь утга, агуулгын өндөр түвшинд бурхны шашны ном судар бичигдсэн байдагтай нь холбоотой.

Эдийн засагч Д.Жаргалсайхан нэгэн удаа Далай ламтай уулзаад монголчуудын алтан хайрцаг нээлгэх ёсны талаар асуухад “Мэдэхгүй, анх удаагаа сонсож байна” гэж хариулсан. Үүнийг болж буддын шашны тэргүүн нь мэдэхгүй гэж байна. Тэгэхээр энэ бол мухар сүсэг юм байна гэх мэт явган яриа хүмүүсийн дунд гарсан. Энэ талаар Та юу хэлэх вэ?

-Монголчуудын, монгол хэлний онцлогт тохирсон үг хэллэг гэж бий. Түүнийг нь яг махчлаад орчуулбал гаднын хүмүүс ойлгохгүй нь мэдээж. Тийм учир Далай ламаас алтан хайрцаг гэж асуух хэрэггүй байсан юм. Өөрөөр хэлбэл шууд “Та “Golden box”-ын талаар юу мэдэх вэ” гэж асуусан гэсэн үг. Үүний оронд үхэгсдийн зурхай гэж орчуулан асуусан бол тэр бээр ойлгох байсан. Шарын шашинд зурхайн ухаан маш сайн хөгжсөн бөгөөд тэр дундаа үхэгсдийн зурхайн салбар судлагдахуун гэж тусдаа маш том зүйл бий.

Дацан, хийд хоёр нь ямар ялгаатай вэ?

-Дацан гэдэг нь тухайн нэг чиглэлээр дагнан сургалт явуулдаг газрыг хэлдэг. Чойрын дацан нь чойрынхоо номыг, эм зурхайн дацан нь эм зурхайнхаа номыг үзнэ гэсэн үг. Дацан хийдэд харьяалагддаг. Тухайлбал, Гандантэгчэнлин хийд чойрын гурав, дүйнхэр, нууц тарнийн, гүрэм, ёога буюу засал хийдэг, эм зурхайн тус тусдаа нэг, нэг дацантай. Ийм цогц байдлаар хүмүүст бурхны шашныг түгээн дэлгэрүүлдэг гэсэн үг. Харин Жавзандамба хутагт төв бол хийд, дацан биш хүмүүсийн санаачлан байгуулсан төрийн бус байгууллага юм.

Шарын шашин дотор улааны урсгал гэж байдаг. Энэ нь хоорондоо юугаараа ялгаатай вэ?

-Улаан, шар, хөх, цагааны урсгал гэж бий. Өмсдөг малгай, хувцас хэрэглээгээрээ л ийнхүү ялгагддаг. Бүгдээрээ бурхны шашны салбар ухаанууд учир тийм ч их ялгаа байхгүй. Сахиус, шүтдэг шүтээнээрээ арай өөр гэж хэлж болох юм. Манайхан улааны урсгалыг гүрэм засал

хийхдээ хүчтэй гэж ташаа ойлгох нь элбэг. Улааны урсгал нь нууц тарнийн ёсыг голчлон судалдаг учир хүмүүст ингэж ойлгогддог байх. Тиймээс бурхан, сахиус нь нууц байх ёстой юм. Тус урсгалын гол төлөөлөгч нь говийн догшин хутагт Данзанравжаа билээ.

Гэхдээ сархад хүртэх, эмэгтэй хүний гоо сайхныг бишрэн шүтэх зэргээрээ шарын шашны урсгалаасаа ялгаатай мэт харагддаг ...

-Нэгэн түүх ярихад, Данзанравжаа өөрийг нь дуурайж, сархад хүртээд байсан шавь нартаа хандаж “Та нар архийг рашаан болгож чадаж байна уу” гэхэд шавь нар нь тийм гэж хариулжээ. Тэгэхээр нь “Тэгвэл архийг рашаан болгон хүртэж чадаж байгаа юм чинь үүнийг рашаан болго” гээд баас, шээс, хог, шороог нэг дор холин зуурч шавь нартаа өгөхөд хоёр нь л түүнийг рашаан болгон хувиргаж чадсан гэдэг. Рашаан гэдэг нь хувиргалт гэсэн утгатай үг юм шүү дээ. Ийм их хүчийг тарнийн ёсоор олж авдаг учир нууц байх ёстой. Ийм юмыг ойлгоход бэрх учир дээр хэлсэнчлэн улс бүхний ард түмэнд дэлгэрээгүй хэрэг. Будда өөрөө бурхан болох гэж тоолшгүй гурван галавт явж буян хураасан. Харин нууц тарнийн ёсоор нэг насанд нь хүнийг бурхан болгож болно. Гэхдээ зарчмын маш нарийн дүрэм, журам чанад

байдаг. Бурхан багш ч мөн ингэж өөрийнхөө сургаал, айлдваруудыг товчилж байсан түүхтэй.

Тэгвэл дэлгэрэнгүй унших шаардлагагүй гэсэн үг үү?

-Унших, судлах хоёр чинь өөр шүү дээ.

Ямар шалгуураар хүмүүсийг лам болгодог юм бэ?

-Хуучны ном, сударт хүнээс хүн чанарыг нь харж лам болго гэсэн байдаг. Түүнээс оюун ухааны чадвар тийм ч чухал биш. Хэдий ухаан хурц ч хүн чанар муутай байх юм бол тэр нь том аюул. Идэр нас, эрх мэдэл, мэргэн ухаан гурав нэг хүний гарт төвлөрвөл дийлдэшгүй аюултай. Одоо бол хүмүүс аль болдоггүйгээ лам болгох гээд байна. “Манай энэ нэг юм хэрэг төвөгт орооцолдчих гээд болохгүй юм. Лам болговол таарна” гэх хүнтэй олон таарч байсан. Сүм, хийд гэдэг чинь айлын аль болдоггүй хүүхдүүдийн цуглаан биш. Гандан, хийд рүү ороод гарах төдийд л хүн тайвшралыг мэдэрдэг. Бурхан, шүтээний хүч гэж бий. Тийм болохоор та буддын шашны талаар ойлголтгүй, итгэдэггүй ч гэсэн цагаан сараараа засал номоо хийлгэх хэрэгтэй. Хархын төдийд ч буян гэж байдаг. Бурхан багшийн үед нэгэн хүн Шаарийбуу лам дээр ирээд лам болох хүсэлтээ хэлэхэд “Лам болоход тухайн хүн ямар нэгэн буяны үйл

Монголчуудын, монгол хэлний онцлогт тохирсон үг хэллэг гэж бий. Түүнийг нь яг махчлаад орчуулбал хэн ч ойлгохгүй нь ойлгомжтой. Тийм учир Далай ламаас алтан хайрцаг гэж асуух хэрэггүй байсан юм. Өөрөөр хэлбэл, шууд “Та “Golden box”-ын талаар юу мэдэх вэ” гэж асуусан гэсэн үг. Үүний оронд үхэгсдийн зурхай гэж орчуулан асуусан бол тэр бээр ойлгох байсан. Шарын шашинд зурхайн ухаан маш сайн хөгжсөн бөгөөд тэр дундаа үхэгсдийн зурхайн салбар судлагдахуун гэж тусдаа маш том зүйл бий.

сэтгэлийг хүнээс шаарддаг. Нэг ч алдаа гаргаж болохгүй маш хүчтэй зэвсэг гэсэн үг. Нууц тарнийн ёсоор орсон л бол бурхан болох эсвэл тамын ёроолд унах гэсэн хоёр зам л хүлээж байдаг. Дундаас нь орхино гэсэн ойлголт байхгүй. Нууц тарнийн ёсоор орсон хуутагтууд хэдий үхсэн ч хэдэн зуун жил өөрийнхөө биеийг амьд мэт байлгаж чаддаг. Энэ бол бясалгалын хамгийн дээд түвшний энгийн хүмүүст мэдэгдэж байгаа нэгэн хэлбэр нь юм.

Ном уншуулах гээд очиход лам нар хураангуйлаад уншихдаг. Энэ нь зөв үү?

-Номын хураангуй, дунд, дэлгэрэнгүй хэлбэр гэж бий. Хэрвээ ном уншуулах гэж ирсэн хүнд дэлгэрэнгүй байдлаар уншиж өгвөл дор хаяж гурван цаг түүнийг хөдөлгөөнгүй суулгана гэсэн үг. Тийм учир хураангуй номыг сонгодог. Үүнийг хэн нэгэн нь дур зоргоороо зохиочихсон юм биш. Тухайн номд гарч буй бүх утга, агуулгыг бүгдийг нь багтаасан байдлаар товчилсон

хийсэн байх учиртай. Харин танд тийм зүйл алга” гэхэд бурхан багш хараад “Танд хийсэн буян байна. Тэртээ 500 галавын үед та хорхой байхдаа борооны уснаас зугтааж суварга тойрсон байна” гэж хэлсэн гэдэг. Тийм учир сүм хийдээр ороод гарах төдийд хүн өөртөө буян хурааж байдаг жамтай юм шүү.

Буддын гүн ухаанаас хүмүүс юуг ойлгох учиртай вэ?

-Бурхны шашны номлолоос хүмүүс маш олон зүйлийг ойлгож, ухаарч болно. Тухайлбал, Будда амьдралын мөн чанарыг тайлбарлахдаа зовлонгоос зовлон руу шилжих хэлбэртэй гэсэн юм. Нэг зовлонгоос нөгөөд шилжих торгон мөчийг бид жаргал гэж эндүүрдэг. Хүмүүс халууцахаараа сэрүүцэхийг хүснэ. Гэтэл удахгүй даарч эхэлнэ. Халуунаас сэрүүн рүү шилжих торгон мөчийг л бид жаргал гэж эндүүрээд байгаа хэрэг. Машин байхгүй нь зовлон, машин авах нь жаргал, машинаа засуулах нь зовлон шүү дээ. Амьдралыг ямар ч асуудалгүй болгоно гэвэл боломжгүй. Усны давлагаа мэт амьдралд арасаасаа асуудлууд гарсаар л байдаг. Үүнийг ухаарчихвал гутраад, зовоод байх шаардлагагүй. Мөн бид аливаа юмсыг мөнх бусын шинж чанартай гэдгийг ухаарах хэрэгтэй. Бурхан багш ч мөн шавь нартаа хэлэхдээ “Та нар намайг мөнх гэж бодоод байх шиг байна. Бодлын чинь мухарт байгаа энэ үзлийг таслахын тулд би мөнх бусыг үзүүлнэ” гээд 81 сүүдэртэйдээ хойшоо харж хэвтэн “Миний шашин дорноос умард зүгт дэлгэрнэ” гэж хэлээд насан өөд болсон. Энэ нь буддын шашин Энэтхэгээс Төвөд, Төвөдөөс Монголд дэлгэрэхийг бэлгэдэж хэлсэн хэрэг.

Ярилцлагын төгсгөлд Таны лам болсон шалтгааны талаар сонсъя гэж бодлоо ...

-Анх гурван настайдаа эмээгээ дагаад Ганданд очиход лам нарын номоо хурж байгаа байдал, тэр орчин, бурхан, сахиуснууд нь надад үлгэрийн мэт санагдсан. Дараа нь 10 настайдаа ээжийгээ дагуулаад лам болохоор Ганданд очсон. Ингээд 1994 оноос Бакула багшийн нэрэмжит сургуульд сурч, дараа нь Энэтхэгт 12 жил ном сурсан. Ингээд эх орондоо ирээд буддын шашны гүн ухаан, утга учрыг хүмүүст ойлгуулах нь миний ажил юм байна гэдгийг ухаарсан гэх үү дээ. Тэгээд “Жавзандамба хутагт төв”-д хүчин зүтгэх болсон доо. Мөн Гандантэгчэнлин хийдэд харьяалагддаг.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

ЦЭРЭГ-УРАН ЗОХИОЛ

ЦЭРГҮҮД ТАНГАРАГ ӨРГӨЖ БАЙНА

Мөнх хөх тэнгэрийн дор
Энхийн салхинд намирах
Алтан соёмбот төрийн далбаан дор
Эх орны хүү болсны баталгаа болгож
Эх орон, ард түмэндээ
Монгол цэргүүд тангараг өргөж байна
Өвөг дээдсийнхээ өвлүүлж үлдээсэн
Туурга тусгаар үндэстнийхээ
Ариун гал голомтоо өмгөөлөн
Харийн дайсны омгийг дарахаар
Дайчин эрс тангараг өргөж байна
Их хар сүлдэндээ хийморио сэргээж
Эх дэлхийнхээ энхийн үйлсэд монгол цэргүүд
Эзэн Чингисийн монгол цэргийн алдрыг мандуулж
Дэлхийн халуун цэгт үүрэг гүйцэтгэхээр
Энхийн монгол цэргүүд тангараг өргөж байна
Эрэлхэг дайчдаараа монгол түмэн бахархаж байна
Эх орон, ард түмэн, цэрэг эрс амь нэгтэй
Дээд тэнгэрийн заяандаа омогшдог
Миний Монголын бор цэргүүд тангараг өргөж байна

“Цэрэг-уран зохиол” булангийн энэ удаагийн дугаарт Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, чөлөөнд байгаа хурандаа Шаравын Эрдэнэбаярын уран бүтээлийг нийтэлж байна. Цэргийн Ерөнхий дээд сургуулийн Артиллерийн курсийн сонсогч насны гэгээн дурсамжаар ажил, амьдралын гараагаа эхлүүлсэн тэр бээр Зэвсэгт хүчний

анги, салбаруудад артиллерийн салааны захирагчаас ангийн захирагч хүртэлх албан тушаалд шат дараалан томилогдож, амжилт дүүрэн ажилласныг хэн бүхэн мэдэх биз ээ. Тэр бээр чөлөөт цагаараа зохиол, яруу найргийг ихэд сонирхож, өөрийн уран бүтээлийн цэнгүүнийг хэдэнтээ зохион байгуулсан эрхэм билээ.

ХАЛХЫН ГОЛЫН ЯЛАЛТ

Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойд

Хүчит танкийн төмөр нударга
Халдсан дайсны омгийг дарсан юм
Хуягт цэргийн ширмэн мөндөр
Хөнөөлт дайсныг хиар цохисон юм
Дайны бурхад их буучдын мэргэн гал
Дайсны зүрхэнд үхлийн харанга дуудсан юм
Дайчин нөхдөө атаканд уриалж
Дархан ялалтаа тунхагласан цуутай
Монгол, Зөвлөлтийн эрэлхэг хөвгүүд
Мөнхийн гавьяа байгуулсан түүхтэй
Халхын голын аймшигт дайнд
Хамтын ялалтаа мандуулсан гавьяатай
Агаарын хөлгийн зоригт шонхрууд
Алдын замналаа тэнгэрт дархалсан юм
Амь дүйсэн эрэлхэг тулалдаанд
Атаатан дайсны сүнсийг зайлуулсан юм
Морин цэргийн туурайн төвөргөөн
Шуналт дайсны зоригийг мохоосон юм
Мохожгүй зоригт монгол цэргийн
Мөнхийн алдрыг түмэнд гайхуулсан юм
Монгол, Зөвлөлтийн эрэлхэг хөвгүүд
Мөнхийн гавьяа байгуулсан түүхтэй
Халхын голын аймшигт дайнд
Хамтын ялалтаа мандуулсан гавьяатай

ЦЭРГИЙН ДАРГЫН ГЭРГИЙ

Хайрт хань Н.Алтанцэцэгт

Цэл залуухан цэцэг шиг цэвэрхэн насандаа
Цэргийн хүүд хайраа өгч, чин сэтгэлээ нээсэн
Хайраар гэрэлтүүлсэн гэрийнхээ хос баганыг түшилцэн
Хүний орчлонгийн жамаар жаргал цэнгэлийг эдэлсэн
Цэргийн даргын гэргий
Цэгц журамт монгол бүсгүй
Орчлонгийн хайрын дууллыг түрлэг нэмэн эгшиглүүлж
Он цагийн урсгалд хайраа дээдлэн мөнхөрсөн
Тэгш дүүрэн амьдралын жаргалын дээдийг хүртсэн
Тэнгэрлэг заяатай тавилангаар ханьсахын жамтай төрсөн
Цэргийн даргын гэргий
Цэвэрхэн төрсөн ихэмсэг бүсгүй
Тушаал авсан цэрэг хүний жаргал зовлонг хамтдаа
жаргаж туулдаг
Түгшүүрийн дохио түргэн жагсаалаар сэтгэл нь догдлон
санаа зовдог
Цэрэг олонд нь хүндлэгдэн, ээж нь болон
мэргэн сургаалаа хайрладаг
Цэргийн хуаранд нь дээдлэгдэн
“Тэргүүн хатагтай”-аар өргөмжлөгддөг
Цэргийн даргын гэргий
Чин зүрхний тангараг өргөсөн цэргийн бүсгүй
Тэнгэрийн тамгатай үрсээ хайраар дээдлэн өсгөсөн
Тэнүүн жаргалтай гэр бүлийнхээ заяаг түшин жаргасан
Хосоор амьдрах хорвоогийн жаргал цэнгэлд умбасан
Ерөөлөөр учирсан ханийнхаа сүлд хийморийг
өндөрт өргөн тахисан
Цэргийн даргын гэргий
Цэнгэл жаргалтай эрхэмсэг бүсгүй
Цэргийн дарга нөхрөө олонд гайхуулж өөрийгөө гоёж, гангардаг
Төрийн төлөө зүтгэсэн гавьяатай үйлсээр нь
сэтгэлээ чимэн бахархдаг
Үүрийн гэгээнээр үдэж, үдшийн бүрийгээр угтахдаа
элгэнд нь тэврүүлж нялхардаг
Алдаж онож, унаж босож, банга донго хүртэн уруу царайлахад нь
Ариухан цайлган сэтгэлээр урам хайрлан түшээд л авдаг
Цэргийн даргын гэргий
Эх орныхоо төлөө хамтдаа зүтгэсэн тэнгэрлэг бүсгүй

ИХ БУУЧДЫН АЛДАР

Удам залгасан эх орончдын
Алдын буухиаг өртөөлөн авч
Улаан залаат монгол их буучдын
Баатарлаг замналаар замнасан
“Шидэх урлаг”-ийг шинжлэх ухаанд хүргэн
Дэлхийн хэмжээнд хөгжүүлсэн
Эрин зууны шилдэг зэвсэглэлээ
Дээд түвшинд чадварлаг эзэмшсэн
Улаан залаат монгол их буучдын
Алдын зам ашид мөнх дэвжин байг
Дайн тулааны талбарт сүр хүчээ гайхуулан
Авралын бурхан лугаа сүслэн шүтэгдсэн
Дайсны зүрхэнд үхлийн харанга болон
Аянга лугаа нүргэлэн цоргисон
Дайчин баатарлаг ялалтын замнал
Түүх шашдирын улбаатай
Даамай бахдам амжилтуудаар
Түүхийн хуудсаа зузаалсан
Дайны бурхад домогт их буучдын
Дайчин баатарлаг үйлс мандан бадраг
Дарийн утаа үнэртсэн аюулт дайны
Ялалтын замыг мэргэн галаараа
Цойлон дагуулсан
Дайчин баатарлаг цэрэг эрсээ
Ялалтын өндөрлөг өөд уриалан дуудсан
Ялсан цэргийнхээ сүр хүчийг
Ялалтын буудлагаараа
Тунхаглан зарласан
Яруу алдарт монгол их буучдын
Мөнхийн гавьяа өнөд мөнх оршвой ...
Улаан залаат монгол их буучдын
Алдын зам ашид мөнх дэвжин байг
Дайны бурхад домогт их буучдын
Дайчин баатарлаг үйлс мандан бадраг

БУРХДЫН ШҮНШИГТЭЙ АНДУУД МИНЬ

Ааг бардам залуухан насандаа
Андгай өргөсөн цэргийн нөхөд минь
Инээж шуугисан идэрхэн насандаа
Ижилдэн дассан их бууч найзууд минь ээ
Замбуулин хорвоод ерөөлөөр учирсан
Бурхдын шүншигтэй андууд минь ээ
Намба суусан тохитойхон насандаа
Наргиж доргисон дотнын андууд минь
Наран хэвийх намбатайхан насандаа ч
Найзын хэлхээ тасрахгүй андууд минь ээ
Замбуулин хорвоод ерөөлөөр учирсан
Бурхдын шүншигтэй андууд минь ээ
Бурхнаас заяасан тоотойхон насандаа
Буян заяагаа холбосон андууд минь
Буурал хорвоогийн түмэн нугачаанд ч
Багын зан нь хувираагүй найзууд минь ээ
Замбуулин хорвоод ерөөлөөр учирсан
Бурхдын шүншигтэй андууд минь ээ

ЭМЧ НАРАА БАЯРЛУУЛЖ ЯВААРАЙ

Хайрт охин, Хилийн цэргийн ахмад Э.Нарантунгалагтаа зориулав

Эхийн хэвлийгээс дуугаа хадаан мэндэлснээс эхлэн
Эргэх хорвоогийн жамаар уруудан гундуухан явахад
Эгэлхэн бие, саруул ухаанаа биднийхээ төлөө зориулдаг
Элбэрэлт эмч нараа хайрлаж яваарай
Хүнлэг нандин сэтгэлээ зон олондоо зориулж
Хүсэл мөрөөдөл бүхэн нь бусдын төлөө тэмүүлсэн
Энэхэн насны амьдралын жаргал, цэнгэлийг атгуулдаг
Энэрэлт эмч нараа хүндэлж яваарай
Аюулын ирмэгт тулж аргаа баран аврал эрэхэд минь
Ариухан цайлган сэтгэлээр урам хайрлаж утгддаг
Жаргал зовлонгийн дэнсэнд бидэнтэйгээ хамт мөнхөрсөн
Өгөөмөр сэтгэлтэй эмч нартаа урам хайрлаарай
Аюулт өвчний оношийг алдалгүй тавьж
Алдан биеэ умартан өдөр шөнөгүй чармайсан
Алтан дэлхийд нэрээ гаргах амьдын баталгаа хайрладаг
Ачлалт эмч нартаа итгэл зүүлээрэй, хүмүүс ээ
Үхэл, амьдралын талбарт өвчнийг даран номхотгоод
Дайснаа дарсан дархан баатар шиг
сэтгэлийн оч нь гялалзсан
Дайчин цолог царайд нь баярын мишээл тодорсон
Даанч даруухан эмч нартаа хүндэтгэл үзүүлээрэй
Энэрэнгүй үйлсийн тэргүүн манлайд одод болон гялалзаж
Эрүүл мэндийн галын шугамд наран болон гэрэлтсэн
Эрдэм ухаан зүрх сэтгэл нь түмэндээ хүндлэгдсэн
Тэнгэрлэг шүтээн эмч нараа баярлуулж яваарай ...



ЦЭРГИЙН ХӨГЖИМ

Цэргийн хөгжмийн 105 жилийн ойд

Сүрлэг жагсаалын алхааг хөглөж
Сүлдэт тугийн дор цэргүүд хөвөрнө (өө)
Гандаж бөхийсөн цэцэгс өндийж
Галын шугамд сумтай нүргэлдэг (ээ)
Ай хө, цэргийн хөгжим
Цэрэг эрсийн золбоо хийморь
Аавын хөвгүүд хуаранд жигдэрч
Аянган түрлэгийг зүрхэнд мөнхөлдөг (өө)
Амгалан цэнхэр уулс сэргэж
Атаатны өөдөөс зоригоо хөвчилдөг (өө)
Ай хө, цэргийн хөгжим
Аавын хүүгийн сэтгэлийн сүлд (ээ)
Эр цэргийн цоглог алхаанд
Эргэх цагийн уяныг түрэлцэнэ
Эрэлхэг хөвгүүдийн хатыг ширээж
Энх цагийн тэнгэрт мөнхөлдөг (өө)
Ай хө, цэргийн хөгжим
Эх орны мөнхийн дуудлага (аа)

ӨМНИЙН ЦЭНХЭР ГОВИЙН ЦЭРЭГ ЭРС

Өмнийн цэнхэр говьдоо гал голомтоо бадрааж
Өлгий сайхан нутгаа нүд цавчилгүй манасан
Алтан шаргал нараа магнай дээрээ залан
Алдарт жанжны алдрыг өнөд мөнх өргөж
Андгай өргөсөн цэрэг эрс алхаж явна (аа)
Аранзал туган доор жигдрэн жагссан
Аавын хөвгүүдийн сүрлэг жагсаал
Алтан соёмбот төрийн далбаагаа
Амгалан хөх тэнгэртээ намуруулан мандуулж
Энхийн үйлсийн төлөө цэрэг эрс дуулж явна (аа)
Моторт хөлгийн сүр хүчийг бадрааж
Монгол цэргийн ид хавыг бахдуулан
Мохожгүй зоригт өвгөдийнхөө алдрыг уламжлан
Мөнхийн гавьяагаа зон олондоо магтуулсан
Мотобуудлагын дайчин хороо маршилж явна (аа)

ХОЙЧ ҮЕДЭЭ ҮЛДЭЭХ СЭТГЭЛИЙН ӨЧИЛ

Үр хүүхэд, ач зээ нартаа
XVII жарны “Ялгуулсан” хэмээх модон морин
жилийн намрын эхэн хар бич сарын шарагчин үхэр
өдрийн шинийн 22-ны билигт сайн өдөр хоёр ихэр
хүү Э.Мөнхбат, Э.Мөнхбаяр хоёрынхоо сээлэг үргээх
найрт зориулан зохиов. Хайртай өвөө нь.


Боржигон халх овогтны голомтыг сахин төрж
Босоо заяатай Бул овогтны удмыг залган мэндэлсэн
Тэнгэрийн тамгатай хөх толбот Монголын
хүү нь билээ та нар
Туурга тусгаар их засагт Монголын үрс нь билээ, та нар
Хэн ч халдашгүй дархан хилээ нүд цавчилгүй манаж
яваарай, хүүхдүүд минь
Хир ч халдаашгүй хэл соёл, түүх шашдираа
хадгалж яваарай, үрс минь
Хэнд ч өгшгүй монгол газар нутгаа хамгаалж яваарай
хүүхдүүд минь
Хэнтэй ч хуваашгүй алт, эрдэнэсээ эдэлж
жаргаж амьдраарай үрс минь
Алтан соёмбот төрийн далбаандаа мэхийн ёсолж
яваарай, үрс минь
Ачлалт төрийнхөө оройн сүлдэнд сүслэн мөргөж
яваарай, хүүхдүүд минь
Ачтай буянтай азай буурал өвөө эмээ нараа ачилж өргөж
яваарай, үрс минь
Алаг хорвоод төрүүлж өсгөсөн аав ээжийгээ дээдэлж
баярлуулж яваарай, хүүхдүүд минь
Алтан ургийнхаа түүх бичээсийг таслалгүй
үргэлжлүүлж яваарай, үрс минь
Ариун журамт удам судраа хиртээлгүй хадгалж
яваарай, хүүхдүүд минь
Ахан дүүс төрөл саднаа марталгүй санаж, хүндэлж
яваарай, үрс минь
Амьдралынхаа сайхан ханийг хайрлаж, жаргааж
яваарай, хүүхдүүд минь
Эрдэм мэдлэг бие сэтгэлээ зөвхөн монголдоо
зориулаарай, хүүхдүүд минь
Эртний уламжлалт ёс жаягаа зөвхөн монголоор нь
хадгалж яваарай, үрс минь
Эцгийнхээ асаасан голомтын галыг өнөд мөнх өргөж
яваарай, үрс минь
Эхийнхээ өргөдөг сүүн цацлыг ашид мөнх өргөж
яваарай, үрс минь
Дээдийн заяатай морьтон Монголын хүүхдүүд шүү, та нар
Дэлхийг бөхөлзүүлсэн эзэн Чингисийн үр сад шүү, та нар



МИНИЙ ТӨРСӨН СҮХБААТАР НУТАГ МИНЬ

Их Монголын үеэс удам судраа хадгалж
Их жанжны нэрийг хийморь сүлдэндээ тахисан
Дорнод Монголын талдаа гал голомтоо бадраасан
Домогт түүхийн алтан өлгий миний төрсөн
Сүхбаатар нутаг минь
Сайхан Монгол орны маань наран ургах зүгийн алтан босго
Сайн эрсийн тэмцэж, боссон шашдир түүхийн
тэмцлийн талбар
Сааршгүй хөгжил нь нийгмийн хонгорынхоо хурдаар
дэвжин цойлсон
Сэтгэлээс уяатай ашдын заяатай миний төрсөн
Сүхбаатар нутаг минь
Шандаст хурдан хөлгүүд нь Монгол даяар гайхагдаж
Шаламгай хүчит бөхчүүд нь зон олноо баясуулсан
Уртын сайхан дуу нь талаа дүүрэн цуурайтсан
Удам сайт буурал дээдсийн маань төрж өссөн нутаг аа
Агь, таана алагласан цэцэгт талд нь зээрийн сүрэг
багшран бэлчсэн
Анагаах увидаст рашаан булаг нь ард олноо
ариусган жаргаасан
Алт эрдэнийн уурхай баялаг нь нутаг орноо
хөгжүүлэн мандуулсан
Алдар хүндийн алтан өлгий, өнөд мөнхийн
төрөлх нутаг минь
Дэлгэр баян таван хошуу малаа шилмэл болгон өсгөсөн
Дээдлэн хүндлэх гавьяат, алдартнуудаар
түүхийн хуудсаа баяжуулсан
Эртний дурсгалт түүх, соёлоо өвлөн авч дээдлэн шүтсэн
Баян тансаг төрөлх нутагтаа эзэн нь болсон
Сүхбаатарчууд минь





Дугаарын зочин

Гэрэл зураг нь түүх өгүүлэхээс гадна мянган асуултын хариулт болдог онцлогтой. Манай улсад гэрэл зургийн салбар үүсэж хөгжөөд 90 гаруй жилийн нүүрийг үзэж байна. Өнгөрсөн хугацаанд гэрэл зурагчдын маань ур чадвар ч үнэмлэхүй дээшилж, мэдрэмж, мэдлэг, оюунаа техник, технологийн дэвшилтэй хослуулан сайн бүтээлийг төрүүлсээр байгаа билээ. Тэдгээр гэрэл зурагчдын төлөөлөл бол Э.Идэрбат. Тэрээр шувуудын торгон агшныг гэрэл зургийн хальснаа буулгадаг юм.

Ярилцлагын эхэнд уншигчдад өөрийгөө танилцуулахгүй юу?

-Би зураглаач мэргэжилтэй. 2016 оноос шувуудын гэрэл зургаар дагнах болсон. Өмнө нь гэрэл зургийн аль нэг урсгал чиглэлийг гол болгож байсангүй. 2007 оноос төрөл бүрийн сэдвээр зураг авч эхэлсэн ч ажил гэхээс илүүтэй хоббиндоо л хөтлөгддөг байв.

Хүмүүс "portrait" буюу хөрөг аль эсвэл байгалийн өнгө төрхийг харуулсан гэрэл зургуудыг сонирхох нь түгээмэл. Гэтэл яагаад шувууны зураг гэж ...

-Би 2016 онд "Хүрээлэн" төслийнхний хамтаар нэвтрүүлгийн зурагт гарцаасан юм. Намрын сэрүү орсон байсан шиг санагдаж байна. Би хэд хэдэн ан амьтны зураг буулгаж амжсан. Орон нутагт ажиллах хугацаа дуусаж хотод ирснийхээ дараа авсан зургуудаа харлаа. Тэр дундаас шувуудын зураг дарах нь илүү тохиромжтой бас сонирхолтой санагдсан. Таны хэлсэнчлэн байгалийн өвөрмөц өнгө төрх эсвэл тухайн нэг хүнийг тодотгож авдаг тийм жишиг гэрэл зурагчдын дунд тогтоод удаж байна. Харин шувуудын тухайд олон төрөл зүйлтэй. Тиймээс зурагчдын өмнө баялаг сонголт бий гэж ойлгож болно. Сайн зураг буулгаж чадвал хүний зан төрх, амьдралын олон өнгийг ч шувуудаас харж болдог онцлогтой.

Тэр бүр тааралдаад байдаггүй ховор шувууд ч байсан. Судалгаагаа хэрхэн хийдэг вэ?

-Хамгийн анх Шивэр энхэт бялзуухай гэдэг шувууны зургийг

авч байлаа. Биеэр ойролцоо учраас хүмүүс болжмортой андуурдаг тал бий л дээ. Тэр шувуу гэхэд л намар Сибириэс сүргээрээ нүүдэллэж ирдэг. Шивэр энхэт бялзуухайтай тааралдъя гэвэл хотын төвд байдаг жимсний моддыг бараадахад л хангалттай. Би ан амьтан, шувуудыг судалдаг мэргэжлийн хүмүүсээс мэдээлэл цуглуулдаг. Сонирхсон шувууд маань хаагуур нутагладаг, өдийд хаана байж болох, ямар онцлогтой гэхчлэн авсан мэдээлэл дээрээ үндэслэн зургандаа гардаг гэх үү дээ. Мөн "Шувуу сонирхогчдын фэйсбүүк групп" бий. Тэр ч бас нэг эх сурвалж нь.

Ихэнх шувууд нүүдлийнх учраас тэдний зургийг зуны улиралд л авах боломжтой байх ...

-Судалгаагаа сайн хийж чадвал өвөлдөө ч зарим шувууны зургийг дарж чадна. Би нэгэн удаа Мандир уранхажин нугасыг манайд нүүдэллэж ирсэн үедээ үржилд ордог тухай олж сонссон юм л даа. Гэхдээ яг ч баримттай олж тогтоосон зүйл байхгүй тэр үед эрэлхийлж явсаар Мандир уранхажин нугасыг дэгдээхэйтэйгээ байхад нь таарч зургийг нь авсан. Энэ нь зарим судлаачдын үзэл бодол, байр суурийг баталсан юм билээ.

Та авсан зургийнхаа доор тайлбар, мэдээлэл зэргийг оруулдаг нь танин мэдэхүйн ач холбогдолтой юм шиг санагддаг ...

-Надтай холбоотой байдаг мэргэжлийн хүмүүс, судлаачдын мэдлэг зузааных шүү дээ. Бас дээрх групп ч нөлөөтэй.

Шувууны нэр, бага зэргийн мэдээллийг багтаадаг нь хийж байгаа зүйлдээ сэтгэлээсээ хандахыг хичээж байгаа нь тэр. Аль болох олон хүнд хүрчихээсэй гэж найддаг. Гэхдээ зарим ховор төрлийн шувуудын байршлын талаарх мэдээллийг тэр болгон хэлээд байхыг

хугацаа зарцуулж дээ. Зуны турш араас нь явсан.

Таны зургууд эерэг энерги түгээдэг. Авсан зургуудаасаа ямар мэдрэмжийг авдаг вэ?

-Авсан зургаасаа амьдралын олон янзын өнгө аясыг мэдрэх гэж хичээдэг. Бас амар амгаланг. Шувууд

ихээхэн тэвчээр шаардана. Та том дурантай байж болох ч ойртохгүй л бол дуранд зэрэглээ орох нь элбэг.

Ашиглаж байгаа камер, дуран, техник хэрэгслүүдээсээ сонирхуулбал ...

-Ихэнх зургаа "Sony A7R II" гэдэг аппарат, "Sigma 150-600"-

Э.Идэрбат: "МАНДИР УРАНХАЖИН" - ТАЙ



хүсдэггүй. Муугаар бодоход өөр санаа өвөрлөсөн этгээд очоод "бодийг нь хөдөлж" орхивол яана гэж сэтгэл зовдог юм.

Хамгийн их цаг зарцуулж, хөдөлмөр шингэсэн нь ямар шувууны зураг вэ?

-Би одоогоор Булган, Өвөрхангай, Хэнтий, Төв зэрэг аймгаар явж зургийнхаа архивыг баяжуулсаар байгаа. Нийтдээ 160 гаруй төрлийн шувуу дурандаа буулгаад байна. Тэр дундаас өнөөх Мандир уранхажин гэдэг гайхлыг авах гэж хамгийн их хөдөлмөр, цаг

харагдах байдлаараа хүнийг тайвшруулдаг онцлогтой.

Сайн бүтээл төрөхийн үндэс нь юу вэ?

-Хүмүүс шувууны зургийг сайн дурантай л бол авчихна гэж эндүүрдэг. Ямар ч тохиолдолд шувуудтайгаа ойртох нь чухал. Намаг, шавартай хутгалдах үе ч бий. Тэр хамаагүй, үнэхээр хүсэж байвал ойртох л хэрэгтэй. Ойртож байхдаа шувуудыг цочоох, айлгаж үргээх үе бийшгүй л бий. Шувуу байгалийн зөн совин өндөртэй амьтан учраас гэрэл зурагчнаас

ийн дурангийн тусламжтайгаар авсан. Сүүлийн жилүүдэд өөр сайн аппарат, дуран юу байна гэдгийг судалж л байна.

Шувуудын гэрэл зургаар дагнах нь Монголд харьцангуй шинэ тугам ойлголт. Харин гаднын улс орнуудад аль үе шатандаа байгаа вэ?

-Гаднын орнуудад үүнийг салбар болтол хөгжүүлсэн нь ч бий. Шувуудаар баялаг манай оронд ч бас хөгжих боломж бий.

Ярилцсанд баярлалаа.

Ц.ЭНХ-ОРГИЛ

ТАНЫГАА АЧЛАХ УРТ ХОЛЫН БОДОЛД ДАРААТАЙ Л ЯВАА ШҮҮ, ЭЭЖ ЭЭ

Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн номын санч Б.Энхтуяагийн санаачилгаар Соёл хүмүүжлийн албанаас нэг сарын хугацаанд ангийн бие бүрэлдэхүүний дунд явуулсан "Талархлын захидал" аянд дэд ахлагч Ү.Урантогосын бичсэн захидал шилдгээр шалгарчээ. Захидлыг хамтдаа задалъя.

Сайн байна уу, ээж ээ. Таныхаа тухай бодож, олон зүйлийг эргэцүүлэн, өдөр бүр хэлж, баярлуулж чаддаггүй байсан тэр л үеэсээ эвлүүлэн энэхүү захидлыг бичиж сууна. Ойрхон байх үедээ их л хэнзэгүй зан гаргаж, уурлаж, гомдоллож байсныг минь уучлаарай. Танаасаа жаахан л холдоход маш ихээр санаж, дэргэд тань байхыг хүсдэг байсан. Дэндүүдээ гэмээр эрх өсчихсөн болохоор ч тэр үү, багахан бэрхшээлийг ч ганцаараа давж чадахгүй

юм. Хайр, халамжаар дутаалгүй өсгөсөн таныгаа бодохоор урам орж, урагш тэмүүлэх итгэл минь нэмээддэг шүү, ээж ээ. Та минь надаа ийм үнэтэй нандин боловч үүнийг би энэ удаагийн шиг нухацтай бодож байсангүй ээ. Таныхаа тухай би яг юу бодох вэ гэж өөрөөсөө асууж үзлээ. Хоёр биеийг өсгөж, хоёр аймайг хамгаалах гэж ижий минь та гэрт орж эм, гадаа гарч эр болж, ертөнцийн өдөр хоногийг ээлж элээхгүй сахиж явсныг тань нялх балчраасаа л би мэднэ. Хоёр үрийнхээ гарыг нь ганзанд, хөлийг нь дөрвөнд хүргэх гэж голын мөсийг долоох шахам явсныг тань зах зухаас нь ч гадарлана. Гэвч би үүнийг эх хүний үүрэг хэмээн санаж, алба мэт бодож явжээ. Уучлаарай, ээж ээ. Дүү бид хоёрыг ганцаараа өсгөсөн он жилүүд, таныхаа залуу насыг бодохоор гол зурах юм. Тэр их хайрын тань ачийг хариулж чадаагүй л явна даа, охин нь. Хэзээ

нэгэн өдөр аливаа зүйлийг хойш тавилгүй одоо л хийж бүтээхийн төлөө тэмцэх болно. Хайртай ээжийгээ бяцхан охиноороо бахархан аз жаргалтай инээмсэглэн байхыг нь харахыг л хүссэндээ тэр шүү дээ, ээж ээ. Та минь охиныхоо хувьд зүгээр л авралын бурхан.

Бурханд хайрлагдсан миний ээж хорвоод заавал урт наслах ёстой шүү. Охин, хүү хоёрынхоо баяр баясал, аз жаргал, амьд бурхан минь. Тандаа мянга мянган оддын тоогоор хайртай. Гэнэн хонгор насны гэгээн хүсэл мөрөөдөл бүхнээ орхиж, намайг л гэсэн энэ их хайраар хайрлагдан өссөн болохоор бусдын амссан элэг бүтэн хайраар хайрлагдсан хайраас илүүтэй сайхан ээжийнхээ энгэрт нь эрхэлсэн юм болохоор дэндүү жаргалтай байдаг шүү, охин нь. Энэ их хайрыг дүү бид хоёрт бэлэглэсэн болохоор ирээдүйд жаргалтай явна гэдэгт та минь итгээрэй. Тандаа хязгааргүй их хайртай шүү, ээж ээ.

ЭМГЭНЭЛ

ГОМБОСҮРЭНГИЙН ЖАДАМБА /1919-2020/



Ахмад дайчин Гомбосүрэнгийн Жадамба нь 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдөр өвчний учир таалал төгсөж, нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Тэрээр 1919 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд төрсөн. Бага насаа эцэг, эхийн гар дээр өнгөрөөж, мал маллаж байгаад цэргийн албанд татагдан улмаар 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин юм. Г.Жадамба нь төрөлх сумандаа багийн дарга, малын эмч, тоо бүртгэгч, нярав зэрэг хариуцлагатай ажил, албыг хашиж, эх орныхоо бүтээн байгуулалтад 46 жил тасралтгүй идэвх зүтгэлтэй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан билээ.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Цэргийн гавьяаны одон, "Бид ялав", "Японыг ялсны төлөө" болон Ардын хувьсгалын ойн медалиудаар шагнасан юм.

Ахмад дайчин Г.Жадамба нь нутаг орондоо нэр хүндтэй, хөдөлмөрч, хүүхэд, залууст эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэхэд үнэтэй сургаалаа хайрласан буянтай буурал байлаа.

Түүний эх оронч, хөдөлмөрч, шударга, нөхөрсөг, элэгсэг дотно, халамжлан хүмүүжүүлэгч зан чанар нь бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ, АХМАДЫН ХОРОО, ТАЛИЙГААЧИЙН ҮР ХҮҮХДҮҮД, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД НЬ

ЦЭРЭНДАГВЫН УЛАМБАЯР /1956-2020/



Чөлөөнд байсан дэд хурандаа Цэрэндагвын Уламбаяр нь хүнд өвчний улмаас таалал төгслөө.

Тэрээр 1956 онд Өмнөговь аймгийн Ноён суманд төрсөн. 1974 онд Ерөнхий боловсролын дунд сургууль, 1982 онд ЗХУ-ын Тамбов хотын Хими хамгаалалтын цэргийн дээд сургууль, 1991 онд ЗХУ-ын Москва хотод Химийн академийн дээд дамжааг төгссөн. 1975-1976 онд Монголын Ардын Армийн 084 дүгээр ангид хугацаат цэргийн алба хаасан. 1982 онд Монголын Ардын Армийн Химийн төв засварын хамгаалах хэрэгслийн цехийн дарга, 1983 онд 289 дүгээр ангийн салааны захирагч, 1984 оноос 139 дүгээр ангийн химийн албаны дарга, 131 дүгээр ангид хими хамгаалалтын тусгай ротын захирагч, 1986 оноос 138 дугаар ангийн химийн албаны дарга, 1992 оноос 119 дүгээр ангийн захирагчийн орлогч-ерөнхий инженер, захирагчийн нэгдүгээр орлогч-штабын дарга, 1998 оноос 167 дугаар ангийн химийн албаны дарга, 2004-2006 онд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн захирагчийн орлогч-ерөнхий инженерээр тус тус үр бүтээлтэй ажилласан юм.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас өндрөөр үнэлж Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний ойн медалиудаар шагнажээ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 119 ДҮГЭЭР АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, ҮЕ ҮЕИЙН ЦЭРГИЙН ХИМИЧИД, НАЙЗ НӨХӨД, ГЭР БҮЛ, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД НЬ

ӨЛЗИЙДҮҮРЭНГИЙН АРИУНБАЯР /1979-2020/



Бидний журмын нөхөр, шилдэг дарга, халамжит хань, хайртай аав, тэргүүн ахлагч Ө.Ариунбаяр нь хүнд өвчний улмаас таалал төгсөж, нөхөж баршгүй хүнд гарз, үй гашуу тохиолоо.

Тэргүүн ахлагч Ө.Ариунбаяр нь 1979 оны 6 дугаар сарын 1-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн. 1997 онд Дархан-Уул аймгийн 17 дугаар сургууль, 1998 онд Батлан хамгаалахын их сургуулийн Ахлагч бэлтгэх төвийг авиа зүйч мэргэжлээр, 2013 онд "Энх-Орчлон" дээд сургуулийг банк, санхүүгийн мэргэжлээр тус тус төгссөн.

Тэрээр 1998-2001 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангид тагнуулын удирдах батареинд авиа зүйч баазын дарга, 2001-2010 онд тагнуулын салааны захирагч, 2010-2013 Батлан хамгаалахын их сургуулийн Артиллери, зэвсгийн тэнхимийн дадлагын багш, 2013-2019 онд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хорооны ахлагч, 2019 оноос Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хорооны ахлагчаар тус тус ажиллаж байсан. Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас өндрөөр үнэлж Цэргийн хүндэт медаль, "Энхийн төлөө", "Дайчин алдар" I, II, III медаль, "Эх орны төлөө" I, II, III хүндэт тэмдэг, "Иракийн эрх чөлөө", "Африкт энхийн төлөө", "Афганистанд энхийн төлөө" дурсгалын тэмдэг, НҮБ-ын медалиар шагнасан юм.

Түүний эгэл даруу, хүнлэг, энэрэнгүй, нөхөрсөг, бүтээлч, хөдөлмөрч зан чанар, элэгсэг дотно дүр төрх бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

ЗХЖШ, ХЗЦК, ҮБХИС, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 120, 186 ДУГААР АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, АХЛАГЧ БЭЛТГЭХ ТӨВИЙГ ХАМТ ТӨГСӨГЧИД, ХАНЬ, ҮР ХҮҮХДҮҮД, ЭГЧ, ДҮҮ, АНД НӨХӨД НЬ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029